


# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

## ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮНД СУРТАЛ АВЛИГА ҮГҮЙ НЭЭЛТТЭЙ ХҮРГЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН**
**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО**

# МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

**9 сар**
**2016**

Улаанбаатар хот

# ГАРЧИГ

Ерөнхий тэмдэглэл ....................................................................................3

Аргачлалын тайлбар ....................................................................................4

Товч танилцуулга ....................................................................................10

Үндсэн үзүүлэлтүүд ....................................................................................26

I. Хүн ам ....................................................................................27

II. Хөдөлмөр ....................................................................................28

III. Боловсрол ....................................................................................29

IV. Нийгмийн даатгал, халамж ....................................................................................31

V. Эрүүл мэнд ....................................................................................33

VI. Байгаль орчин ....................................................................................38

VII. Гэмт хэрэг ....................................................................................42

VIII. Мөнгө, зээл, үнэт цаасны зах зээл ....................................................................................46

IX. Улсын нэгдсэн төсөв ....................................................................................53

X. Гадаад худалдаа ....................................................................................58

XI. Үнэ ....................................................................................69

XII. Статистикийн бизнес регистрийн сан ....................................................................................93

XIII. Хөдөө аж ахуй ....................................................................................97

XIV. Аж үйлдвэр ....................................................................................107

XV. Барилга ....................................................................................112

XVI. Тээвэр, холбоо ....................................................................................114

XVII. Аялал жуулчлал ....................................................................................118

Хавсралт ....................................................................................120

Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм ....................................................................................129

## Ерөнхий тэмдэглэл

I. Товчилсон тэмдэглэгээ:

| | |
|---|---|
| АР | Архангай |
| БӨ | Баян-Өлгий |
| БХ | Баянхонгор |
| БУ | Булган |
| ГО | Говь-Алтай |
| ДО | Дорноговь |
| ДД | Дорнод |
| ДУ | Дундговь |
| ЗА | Завхан |
| ӨВ | Өвөрхангай |
| ӨМ | Өмнөговь |
| СҮ | Сүхбаатар |
| СЭ | Сэлэнгэ |
| ТӨ | Төв |
| УВ | Увс |
| ХО | Ховд |
| ХӨ | Хөвсгөл |
| ХЭ | Хэнтий |
| ДА | Дархан-Уул |
| УБ | Улаанбаатар |
| ОР | Орхон |
| ГС | Говьсүмбэр |

II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв
(I, II, III, IV, V... г.м)
Тухайн сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XI зэргээр илэрхийлэв.

III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

| | |
|---|---|
| ... | мэдээлэл байхгүй |
| 0.0 | маш бага тоо |
| - | гүйцэтгэл байхгүй. |

Г “Үүнээс” гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

IV. Орон дэвшүүлэлтээс хамаарч зарим үзүүлэлтийн нийлбэр нь дүнтэйгээ, бүтцийг хувиар илэрхийлэхэд 100 хувиас бага зэрэг зөрүүтэй байж болно.

## Аргачлалын тайлбар

### Хөдөлмөр

Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-д тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна.

Ажиллагч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг хэв шинж (статус)-д хамрагдаж буй иргэнийг ойлгоно. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон иргэнийг ажиллагчдад хамруулна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс, хөдөлмөрийн төв бирж, хөдөлмөрийн хувийн биржид бүртгүүлсэн ажилгүй иргэдийг хамруулна.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг 2005 оны зэрэгцүүлэх үнээр тооцохдоо зэрэгцүүлэх үнээрх нийт үйлдвэрлэлийн хэмжээг ажиллагчдын дундаж тоонд хуваана.

Тайлант хугацаанд олгосон цалин, түүнтэй адилтгах орлогын нийт хэмжээг ажиллагчдын дундаж тоонд хувааж, аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалинг тооцно. Цалин, түүнтэй адилтгах орлогод үндсэн цалин, нэмэгдэл хөлс,шагнал урамшуулал, цалинтай адилтгах бусад орлогыг оруулна.

### Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого (ҮОХХ)

Үйлдвэрлэлийн осол гэж хөдөлмөр эрхлэгч иргэн хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцад үйлдвэрлэлийн болон түүнтэй адилтгах хүчин зүйлийн үйлчлэлд өртөхийг ойлгоно.

Хурц хордлого гэж цацраг болон биологийн идэвхт бодис, химийн хорт бодисын нөлөөгөөр хурц, цочмог хэлбэрээр богино хугацаанд хордохыг ойлгоно.

Осолдогч гэж үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн ажилтан, иргэнийг хэлнэ.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн нэг ажилтан, иргэнийг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын нэг тохиолдол гэж үзнэ. Хэрвээ нэг осол, хордлогод нэгээс дээш тооны хүн өртсөн бол осолдогч тус бүрээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол гэж тооцно.

Бүлэг осол, хурц хордлого гэж нэг үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод 2 буюу түүнээс дээш тооны ажилтан, иргэн өртөхийг ойлгоно

### Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм. Тэтгэврийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний, ажилгүйдлийн даатгал гэсэн төрлөөс нийгмийн даатгал бүрдэнэ.

Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.

Тэтгэвэр нь даатгуулагчийг өндөр наслахад насан туршид нь, хөгжлийн бэрхшээлтэй болоход хөдөлмөрийн чадвар нь сэргээгдэх хүртэл, эсхүл өндөр насны тэтгэвэр авах насанд хүртэл, нас барахад нь түүний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд /хүүхэд 16 нас, сургуульд суралцаж байгаа бол 19 нас хүртэл /-ийн нийгмийн баталгааг хангах зорилгоор нийгмийн даатгалын сангаас олгох мөнгөн хөрөнгө байна.

Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах ,жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчид нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн

хөрөнгө байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

**Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг тодорхойлохдоо тухайн хугацаанд 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулна.

Амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох хүүхдийн эндэгдлийг тооцохдоо тухайн хугацаанд 5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог амьд төрсөн хүүхдийн тоонд хуваана.

Эндсэн эхийн тоонд жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Халдварт өвчний өвчлөлийн 10000 хүнд ногдох түвшинг тооцохдоо тайлант хугацаанд амбулаторийн үзлэгээр шинээр бүртгэгдсэн нийт халдварт өвчний тохиолдлын тоог тухайн хугацааны хүн амын тоонд харьцуулна.

**Байгаль орчин**

Агаарын бохирдол гэж агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Хүлцэх агууламж гэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин гэж хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

**Аюулт үзэгдэл, осол**

Гамшиг гэж аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг хэлнэ.

Аюулт үзэгдэл гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг хамруулан ойлгоно.

Техникийн холбогдолтой осол гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга,байгууламж, шугам, сүлжээ эвдрэх, тээврийн хэрэгсэл осолдох сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэргийг хамруулан ойлгоно.

**Гэмт хэрэг**

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ.

Гэмт хэргийн нийгмийн шинж чанар, аюулын хэр хэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна.

Тухайлбал:

- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй

байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг;
- Бусад гэмт хэрэг.

18 ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэргийн тоог тодорхойлохдоо нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог 18 ба түүнээс дээш насны хүн амын дундаж тоонд харьцуулна.

Дор дурьдсан этгээдэд хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч эрүүгийн хэрэг үүсгэж, үндэслэл бүхий тогтоол гаргасан бол сэжигтнээр тооцно. Үүнд:
- Уг этгээдийг гэмт хэрэг үйлдэж байх үед буюу үйлдсэн дор нь барьсан;
- Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хохирогч буюу харсан хүн шууд заасан;
- Уг этгээдийн бие, хувцас, эд зүйл, орон байранд гэмт хэргийн ул мөр тодорхой илэрч олдсон;
- Уг этгээд хэргээ илчлэн ирсэн;
- Гэмт хэрэгт сэрдэгдэх үндэслэл бүхий бусад баримт байгаа бол.

Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонсгосон этгээдийг яллагдагчаар тооцно.

**Мөнгө, банк, даатгал**

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгийг банкнаас гадуурх мөнгө болон банкны касс дахь бэлэн мөнгөний нийлбэрээр тооцно.

Бага мөнгө /М1/-ийг банкнаас гадуурх мөнгө болон төгрөгийн харилцах дансан дахь мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Банкнаас гадуурх мөнгийг тооцохдоо Төв банкнаас гүйлгээнд гаргасан цаасан болон зоосон мөнгөнөөс банкуудын эзэмшиж буй цаасан болон зоосон мөнгийг хасна.

Төгрөгийн харилцах дансан дахь мөнгийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөгийн харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Бараг мөнгийг төгрөгийн болон гадаад валютын хадгаламж, валютын харилцах, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тодорхойлно.

Төгрөг болон валютын хадгаламжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын төгрөг, валютын хадгаламжийн үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Валютын харилцахыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын валютын харилцах дансны үлдэгдлийн нийлбэрээр тооцно.

Мөнгөний нийлүүлэлтэд зөвхөн цэвэршүүлсэн алтны харилцах дансны үлдэгдэл хамрагдах бөгөөд бусад үнэт металлын харилцах дансны үлдэгдлийг хамруулахгүй.

Хадгаламжийн сертификатыг арилжааны банкнаас гаргасан иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшиж буй хадгаламжийн сертификатаар тооцно.

Мөнгөний нийлүүлэлт /М2/-ийг банкнаас гадуурх мөнгө, төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж, цэвэршүүлсэн алтны харилцах, хадгаламжийн сертификатын нийлбэрээр тооцно. Өөрөөр хэлбэл, бага мөнгө болон бараг мөнгөний нийлбэрээр тодорхойлно.

Нөөц мөнгө /М0/-ийг банкны касст байгаа бэлэн мөнгө, банкнаас гадуурх мөнгө болон Монголбанк дахь банкуудын төгрөг, валютын харилцах, валютын хадгаламжийн нийлбэрээр тодорхойлно.

Хэвийн зээл гэж төлөвлөгдсөн хугацаанд байгаа зээл, түүний хүүг ойлгоно.

Хугацаа хэтэрсэн зээлийг зээл, хүүгийн хугацаа 90 хүртэл хоног хэтэрсэн зээлээр тодорхойлогдоно.

Чанаргүй зээлийг хэвийн бус, эргэлзээтэй, муу зээл буюу зээл, хүүгийн хугацаа 91-ээс дээш хоног хэтэрсэн зээлээр тооцож гаргана.

Гадаад валютын албан нөөцөд Монголбанкны эзэмшилд байгаа, захиран зарцуулахад бэлэн, чөлөөтэй хөрвөдөг гадаад валют хамрагдана.

Үнэт цаас гэж Засгийн газар болон бусад эрх бүхий этгээдээс гаргасан өрийн бичиг /бонд/, компаний бүх төрлийн хувьцаа, компаний гаргасан, эсхүл гаргахаар санал болгож буй хувьцааг худалдах, худалдан авах эрхийн бичиг (опцион), хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа, түүнчлэн Санхүүгийн зохицуулах хорооноос “Үнэт цаасны зах зээлийн тухай” Монгол Улсын хуульд нийцүүлэн үнэт цаас гэж тодорхойлсон баримтыг;

Өрийн бичиг (бонд) гэж тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсхүл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаасыг;

Хувьцаа гэж компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг;

Брокерийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны зах зээлд бусдын нэрийн өмнөөс үнэт цаасыг зуучлан худалдах, худалдан авах ажиллагааг;

Дилерийн үйл ажиллагаа гэж үнэт цаасны зах зээлд ашиг олох зорилгоор үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авах, худалдах, арилжих ажиллагааг;

Хэлцэл гэж үнэт цаасыг худалдах захиалгын үнийн саналыг худалдан авах иргэд, аж ахуйн нэгж, байгууллага зөвшөөрснөөр үнэт цаас арилжаалахыг;

Бүртгэлтэй компаний тоо гэж Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцааны арилжааг идэвхтэй хийдэг хувьцаат компаний тоог ойлгоно.

Зах зээлийн үнэлгээг Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаний нийтэд гаргасан үнэт цаасны тоо, тухайн өдрийн үнэт цаасны арилжааны хаалтын ханшны үржвэрээр тодорхойлно.

ТОП -20 индекс нь үнэт цаасны үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн үнэлгээ, үнэт цаасны өсөлт, бууралтаар үнэт цаасны зах зээлийн ерөнхий чиг хандлагыг тодорхойлно. Индексийг дараахь томьёогоор тооцно.

$$I = \frac{P}{C} * 100$$

$I$ - Тухайн өдрийн индекс
$P$ - Тухайн өдрийн зах зээлийн үнэлгээ
$C$ - Зах зээлийн суурь үнэлгээ

**Төрийн санхүү**

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, хүний хөгжил сангийн төсөв болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Улсын Их Хурал (УИХ)-аас батлан Засгийн газар бүрдүүлж зарцуулах төсөв нь улсын төсөв, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга бүрдүүлж зарцуулах төсөв нь орон нутгийн төсөв байна.

Төсвийн орлого нь тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ.

Тэнцвэржүүлсэн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос урсгал орлого бүрдэнэ.

Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон татварын бус бусад орлогоос татварын бус орлого бүрдэнэ.

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба урсгал шилжүүлгээс урсгал зардал бүрдэнэ.

УИХ-аас 2010 оны 6 сарын 24-ний өдөр батлагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.5-т нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого нь гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн суурь орлогын нийлбэр гэж заасны дагуу нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тэнцлийг тооцож байна. Гол нэр төрлийн эрдэс баялаг гэж жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг нь бүрдүүлж байгаа тухайн төрлийн эрдэс баялгийг ойлгоно. Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого гэж жилийн нэгдсэн төсвийн орлогын гурав ба түүнээс дээш хувийг бүрдүүлж байгаа тухайн ямар төрлийн эрдэс баялгаас уг хуулийн 11.1.3-т заасны дагуу тодорхойлсон үнийн түвшинг баримтлан тооцож төсөвт оруулах орлогын дүнг ойлгоно.

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, нэгдсэн төсвийн нийт зарлагын зөрүүгээр тодорхойлно.

**Гадаад худалдаа**

Гаалийн ерөнхий газрын статистикт үндэслэн гадаад худалдааны салбарын үндсэн үзүүлэлтийг тооцож байна. Түүнчлэн Дэлхийн худалдааны байгууллагаас зөвлөмж болгосон “Бараag тодорхойлох, кодлох,

уялдуулсан систем"-ийн ангиллын дагуу барааны бүлэг, нэр төрлийг тогтоодог.

Барааны экспорт гэж Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрээс эргэн оруулах үүрэггүйгээр барааг гадаадад гаргахыг ойлгоно.

Барааны экспортод эх орны үйлдвэрлэлийн барааг гадаадад гаргах, мөн реэкспортыг оруулна. Эх орны үйлдвэрлэлийн бараанд мөн түүнчлэн улс оронд оруулсан, дахин боловсруулалт хийсэн, үндсэн чанар буюу техникийн шинжийг өөрчилсөн гадаад гаралтай барааг оруулна.

Барааны реэкспортод Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт урьд нь оруулсан боловч ямар нэг дахин боловсруулалт хийгдээгүй, гаалийн татвар, хураамж болон төлбөргүй, эдийн засгийн хориг хязгаарлалтгүйгээр гадаадад гаргасан барааг оруулна.

Барааны импорт гэж эргүүлж гаргах үүрэггүйгээр Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт гадаадаас бараа оруулахыг ойлгоно.

Импортод улс орны эдийн засгийн хэрэглээнд зориулж гадаадаас оруулсан бараа, мөн реимпортлох барааг хамруулна. Реимпортын бараанд Монгол Улсын нутаг дэвсгэрээс урьд нь гаргасан хэдий ч эргүүлэн оруулсан барааг оруулна.

Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны барааны нийт эргэлтийг тодорхойлно.

Нийт экспортоос импортыг хассан зөрүүгээр тэнцлийг тодорхойлно. Тэнцэл (-) тэмдэгтэй бол алдагдалтай, (+) тэмдэгтэй бол ашигтай гэж үзнэ.

**Үнэ**

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийн жин юм.

ХҮИ-ийн тооцоонд Ласпейресийн үнийн индексийн дараах томьёог ашиглаж байна.

$$I_p^L = \frac{\sum_{i=1} p_{it} * q_{io}}{\sum_{i=1}^{n} p_{io} * q_{io}}$$

$I_p^L$ - t тайлант үеийн Ласпейресийн үнийн индекс

t - тайлант үе,

0 - суурь үе

$p_{it}$ - 'i' барааны тайлант үеийн үнэ,

$p_{io}$ - 'i' барааны суурь үеийн үнэ,

$q_{io}$ - 'i' барааны суурь үеийн худалдан авсан тоо, хэмжээ

$\sum$ - нийлбэрийн тэмдэг

Үнэ өсч тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг инфляци гэдэг. Инфляцын түвшинг тооцохдоо дараах томьёог ашиглана.

Үүнд:

$$\text{Инфляцийн түвшин} = \frac{I_t - I_o}{I_o} * 100$$

$I_t$ - тайлант үеийн үнийн индекс

$I_o$ - суурь үеийн үнийн индекс

Өрхийн нийгэм, эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний сагсан дахь нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), хэрэглээний зардлын жинг шинэчилж, 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг тооцоход ашиглаж байна.

Хөдөө аж ахуйн гол нэрийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн үнэ цуглуулах нэгжүүдээс сар бүр авч, сарын дундаж үнийг тооцож байна.

## Хөдөө аж ахуй

Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, гол мөрөн, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

## Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-аас гишүүн орнууддаа мөрдөхийг зөвлөмж болгосон эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны олон улсын стандарт ангилалд үндэслэсэн үндэсний ангиллыг мөрдөж байна.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг сар бүрийн мэдээлэлд хамруулан судалж, үйлдвэрлэлийн биет хэмжээний индексийг тооцно. Уг индексийг тооцохдоо Ласпейресийн биет хэмжээний индексийн томьёог ашиглана.

$$I_Q = \frac{\sum (Q_t \cdot P_0)}{\sum (Q_0 \cdot P_0)} \cdot 100 = \sum (\frac{Q_t}{Q_0}) \cdot W_0 \cdot 100$$

$Q_t$ - Тайлант үеийн бүтээгдэхүүний биет хэмжээ
$Q_0$ - Суурь үеийн бүтээгдэхүүний биет хэмжээ
$P_0$ - Суурь үеийн бүтээгдэхүүний үнэ
$W_0$ - Жин

## Тээвэр

Ачаа эргэлтийг тооцохдоо тээвэрлэсэн ачааг тээсэн зай/км/-аар үржүүлнэ.

Зорчигч эргэлт нь зорчсон зорчигчдын тоо, аялсан зайн үржвэрээр илэрхийлэгдэнэ.

Шилжүүлсэн тн.км гэж тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлтийг ойлгоно.

Тээврийн орлого нь ачаа, зорчигч тээвэрлэлт, түүнтэй холбогдох үйл ажиллагаанаас орсон орлого юм.

**Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал**
(2016 оны эхний 9 сарын байдлаар)

## I. Нийгмийн үзүүлэлт

### I.1 Хүн ам

Улсын хэмжээнд 2016 оны эхний 9 сард 59042 эх амаржиж, 59320 хүүхэд төрүүлсэн байна. Харин нас баралт 12292 болж, өмнөх оны мөн үеийнхээс 45 буюу 0.4 хувиар өсчээ.

1000 хүн тутамд 19.5 хүүхэд төрж, 4.0 хүн нас барж, ердийн цэвэр өсөлт 15.5 хүн болов. Өмнөх оны мөн үеийнхээс 1000 хүнд ногдох төрөлт 0.9 пункт, нас баралт 0.1 пункт, хүн амын ердийн цэвэр өсөлт 0.8 пунктээр буурлаа.

Зураг I.1

**1000 хүнд ногдох төрөлт, нас баралт, ердийн цэвэр өсөлт,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Энэ оны эхний 9 сард 1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас Улаанбаатар хотод 2.9, Баян-Өлгий 1.8, Говьсүмбэр 1.8, Дорнод 0.9, Ховд аймагт 0.7 пунктээр дээгүүр, харин Төв 9.2, Булган 8.3, Сэлэнгэ 5.9, Завхан 3.6, Архангай 3.5, Говь-Алтай 3.4, Сүхбаатар 3.1, Дундговь 3.0, Дорноговь 2.6, Өмнөговь 2.5, Хэнтий 2.3, Хөвсгөл 2.0, Баянхонгор 1.7, Өвөрхангай 1.5, Дархан-Уул 0.5, Увс аймагт 0.4 пунктээр доогуур байна. Орхон аймаг улсын дундажтай ижил түвшинд байна.

1000 хүнд ногдох нас баралт Дорнодод 1.0, Баянхонгор, Хөвсгөлд тус бүр 0.7, Дундговь 0.6, Өвөрхангай 0.5, Увс, Сүхбаатарт тус бүр 0.4, Говь-Алтай 0.3, Булган, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ аймагт тус бүр 0.1 пунктээр улсын дунджаас дээгүүр, харин Говьсүмбэр 0.7, Ховд 0.6, Хэнтий, Төв аймагт тус бүр 0.3, Улаанбаатар, Өмнөговь, Архангай аймагт тус бүр 0.1 пунктээр улсын дунджаас доогуур, Орхон, Завхан, Баян-Өлгий аймагт улсын дундажтай ижил түвшинд байна.

Хүн амын ердийн цэвэр өсөлт Улаанбаатар хотод 3.0 пункт, Говьсүмбэр 2.5, Баян-Өлгий 1.8, Ховд аймагт 1.3 пунктээр улсын дунджаас дээгүүр, бусад аймагт 0.1-8.9 пунктээр улсын дунджаас доогуур байна. Харин Орхон аймагт улсын дундажтай ижил түвшинд байна.

### Хөдөлмөр

### I.2 Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого (ҮОХХ)

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын мэдээллээр үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдол улсын хэмжээнд 2016 оны эхний 9 сард 191 бүртгэгдсэнээс 189 буюу 99.0 хувь нь үйлдвэрлэлийн осол, 2 буюу 1.0 хувь нь хурц хордлого байна. Энэ оны 3 дугаар улиралд үйлдвэрлэлийн осол, хурц хордлого 65 бүртгэгдсэний 64 нь үйлдвэрлэлийн осол, 1 нь хурц хордлого байна.

Үйлдвэрлэлийн ослын 189 тохиолдлоос 5 нь бүлэг осол байна. Эдгээр үйлдвэрлэлийн ослын 39.7 хувь нь унах, бүдрэх, хальтрах, 12.7 хувь нь эд зүйлд хавчуулагдах, 9.5 хувь нь унаж буй эд зүйлд цохигдох шалтгааны улмаас гарсан осол эзэлж байна.

Зураг I.2

**Үйлдвэрлэлийн осол,** ослын шалтгаанаар, 2016 оны эхний 9 сарын байдлаар




*Эх үүсвэр: Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улирлын мэдээ*

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас осолдогчид 2016 оны эхний 9 сард 191 байгаагийн 99 буюу 51.8 хувь нь хүнд, 75 буюу 39.3 хувь нь хөнгөн хэлбэрээр гэмтэж, 17 буюу 8.9 хувь нь нас барсан байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод осолдогчдын 61 буюу 31.9 хувь нь эмэгтэйчүүд байна. Мөн нийт осолдогчдыг эрхэлж байсан ажил мэргэжлээр авч үзвэл, 32.5 хувь нь энгийн ажил мэргэжилтэй, 14.7 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 14.1 хувь нь мэргэжилтэн, 12.0 хувь нь суурин тоног төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч, 8.4 хувь нь техникч болон туслах, дэд мэргэжилтэй, 8.4 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 5.8 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 2.6 хувь нь менежер, 1.0 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 0.5 хувь нь ХАА, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан байна.

Зураг I.3

**Осолдогчид,** ажил мэргэжлээр, 2016 оны эхний 9 сарын байдлаар




*Эх үүсвэр: Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улирлын мэдээ*

## I.3. Боловсрол

Бүх шатны сургуулийг 2015/2016 оны хичээлийн жилд 111.8 мян.суралцагчид төгссөнөөс ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийг 56.4 мян.сурагч (9-р ангийг 21.2 мянга, 12-р ангийг 35.2 мянга), мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв (МСҮТ)-ийг 19.5 мян.суралцагчид, их, дээд сургууль, коллежийг 35.9 мян.оюутан төгсчээ.

Зураг I.4

**Бүх шатны сургуулийг төгсөгчид,** мян.хүн




Их, дээд сургууль, коллежийг 2015/2016 оны хичээлийн жилд нийт 35.9 мян.оюутан төгссөн нь өмнөх оныхоос 0.7 мянга буюу 2.0 хувиар өсөв.

Нийт төгсөгчдийн 52.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

## I.3 Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 9 сард 1303.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 258.9 тэрбум төг буюу 24.8 хувиар, зарлага 1276.7 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 123.2 тэрбум төг буюу 10.7 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 258.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд тэтгэврийн даатгалын сангийн орлого 216.3 тэрбум төг буюу 30.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 123.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага 0.3 тэрбум төг буюу 0.1 хувиар буурсан хэдий ч тэтгэврийн даатгалын сангийн зарлага 84.7 тэрбум төг буюу 9.4 хувиар, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 29.7 тэрбум төг буюу 20.1 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

### Нийгмийн халамж

Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 9 сард 250.6 мян. хүнд 112.5 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчид 57.9 мянга буюу 30.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 3.3 тэрбум төг буюу 3.0 хувиар өсчээ. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2016 оны эхний 9 сард 62.9 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 0.2 мянга буюу 0.2 хувиар буурч, олгосон тэтгэврийн хэмжээ 0.8 тэрбум төг буюу 1.2 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 2016 оны эхний 9 сард 557.2 мян.хүн хамрагдсаны 48.4 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 47.8 хувь нь ахмад настан, 3.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0.5 хувь нь алдар цолтой ахмад настай иргэд, 0.3 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлтөд 66.1 тэрбум төг олгосон нь өмнөх оны мөн үеийнхээс 1.1 тэрбум төг буюу 1.7 хувиар өсчээ.

“Хүний хөгжил” сангаас эхний 9 сард 18 хүртэлх насны 1021.1 мянган хүүхдэд 159.4 тэрбум төгрөгийг (2016 оны 10 дугаар сард нийт хүүхдийн 60 хувьд буюу дунджаар 613.8 мян хүүхдэд олгосон 2016 оны 7, 8, 9 дүгээр сарын хүүхдийн мөнгийг оруулж тооцсон дүнгээр) хүүхдийн мөнгөнд олгожээ.

## I.4 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2016 оны эхний 9 сард 59042 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 59320 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 1472 буюу 2.4 хувиар, амьд төрсөн хүүхэд 1529 буюу 2.5 хувиар буурсан байна. Энэ оны 9 дүгээр сард 6533 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 6560 болж, өмнөх сарынхаас амаржсан эх 370 буюу 5.4 хувиар, амьд төрсөн хүүхэд 384 буюу 5.5 хувиар буурчээ.

Зураг I.5

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Улсын хэмжээгээр 2016 оны эхний 9 сард нялхсын эндэгдэл 1063 болж, өмнөх оны мөн үеийнхээс 142 буюу 15.4 хувиар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1297 болж, өмнөх оны мөн үеийнхээс 199 буюу 18.1 хувиар өссөн байна. Нялхсын эндэгдэлд улаанбурхан болон амьсгалын тогтолцооны өвчлөл голлон нөлөөлжээ.

Зураг I.6

**Нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Нялхсын эндэгдэл энэ оны 9 дүгээр сард 86 болж, өмнөх сарынхаас 8 буюу 10.3 хувиар, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 114 болж, 5 буюу 4.6 хувиар өсчээ.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2016 оны эхний 9 сард 17.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.8 пунктээр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 21.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.9 пунктээр өссөн байна.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл энэ оны 9 дүгээр сард 13.1 болж, өмнөх сарынхаас 1.9 пунктээр, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17.4 болж, өмнөх сарынхаас 1.7 пунктээр өсчээ.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 2016 оны эхний 9 сард 59599 болж, өмнөх оны мөн үеийнхээс 10774 буюу 22.1 хувиар нэмэгдэхэд мөөгөнцрөөр өвчлөгчид 419 буюу 31.3 хувиар, вирүст хепатитаар өвчлөгчид 236 буюу 36.4 хувиар, тэмбүүгээр өвчлөгчид 1246 буюу 22.1 хувиар, гонококкт халдвараар өвчлөгчид 643 буюу 17.1 хувиар, сүрьеэгээр өвчлөгчид 191 буюу 5.5 хувиар буурсан хэдий ч улаанбурханаар өвчлөгчид 8155 буюу 36.9 хувь, гар, хөл, амны өвчнөөр өвчлөгчид 4000 буюу 4.3 дахин өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Энэ оны 9 дүгээр сард улаанбурханаар өвчлөгчид 17 болж, өмнөх сарынхаас 70 буюу 80.5 хувиар буурчээ.

Зураг I.7

**10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчид,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Улаанбаатар хотод 2016 оны 9 дүгээр сард ХДХВ/ДОХ-ын тохиолдол 3 илэрч, улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 218 боллоо.

## I.5 Байгаль орчин

### Цаг уур, агаарын бохирдол

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн мэдээгээр 2016 оны 9 дүгээр сард хамгийн их хур тунадас Хэнтий аймгийн Баян-Овоо суманд 144.4 мм-т хүрсэн байна. Хамгийн их температур Өмнөговь аймгийн Сайхан суманд 32.0 хэм, хамгийн бага температур Баянхонгор аймгийн Баянбулаг суманд -10.0 хэмд хүрлээ. Салхины хамгийн их хурд Говь-Алтайн аймгийн Алтай сумαнд 25 м/с байв.

Аймгийн төв болон Улаанбаатар хотын агаарын дундаж хэм 2016 оны 9 дүгээр сард олон жилийн дунджаас 1.6 хэмээр дулаан, өмнөх сарынхаас 0.1 хэмээр хүйтэн, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 хэмээр дулаан байлаа.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2016 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 28 удаа, Баруун 4 зам орчимд 26 удаа, офицеруудын ордон орчимд 3 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт болон 32-ын тойрог орчимд тус бүр 23 удаа, Телевиз орчимд 21 удаа, Хархорин зах орчимд 15 удаа, Амгалан орчимд 11 удаа, Баруун 4 зам орчимд 4 удаа, 1-р хороолол, 13-р хороолол болон нисэх орчимд тус бүр 3 удаа, 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Толгойт орчимд 8 удаа, Телевиз орчимд 7 удаа, Баруун 4 зам, Нисэх, болон Амгалан орчимд тус бүр 3 удаа, 13-р хороолол орчимд 2 удаа чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс давсан байна.

Зураг I.8

**Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн агууламж,** эхний 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)




Зураг I.9

**Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн агууламж,** эхний 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)




Зураг I.10

**Улаанбаатар хотын агаар дахь 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж,** эхний 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)




Зураг I.11

**Улаанбаатар хотын агаар дахь 2.5 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж,** эхний 8 харуулын дундаж, сараар, (мг/м3)




### Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, осол 2016 оны эхний 9 сард 3386 удаа гарч, 181 хүн амь насаа алдаж, 1048.4 мян.толгой мал, тэжээвэр амьтан хорогджээ. Харин объектын түймэр 2823 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 75 удаа, хонины цэцэг өвчин 87 удаа бүртгэгджээ.

Объектын түймрийн улмаас 6.6 тэрбум төгрөгийн хохирол учирч, аюулт үзэгдэл, осолд нийт 524.8 сая төг зарцуулсан байна.

Усны ослын улмаас 130 хүн, объектын түймрийн улмаас 25 хүн, бичил уурхайн нурангины ослоос 13 хүн, үерийн улмаас 4 хүн, ой хээрийн түймэр, аянгын улмаас тус бүр 3 хүн, хүчтэй салхи шуурганы улмаас 2 хүн, тэсрэлт дэлбэрэлтийн улмаас 1 хүн амь насаа алджээ.

Хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтад 2016 оны эхний 9 сард 1048.4 мянгад хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 884.6 мян.толгойгоор нэмэгдсэн байна. Нийт хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтдын 99.7 хувь нь ус, цаг агаарын болон биологийн гаралтай аюулт үзэгдлийн улмаас хорогдсон байна.

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 3386 болж, өмнөх оны мөн үеийнхээс 762 буюу 18.4 хувиар буурав.

Хүснэгт I.1

**Аюулт үзэгдэл, осол,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар*

| Үзүүлэлт | 2014 I-IX | 2015 I-IX | 2016 I-IX | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|
| Аюулт үзэгдэл, ослын тохиолдол | 3 409 | 4 148 | 3 386 | 81.6 |
| Аюулт үзэгдэл, ослын улмаас амь насаа алдсан хүн | 157 | 170 | 181 | 106.5 |
| Шатсан гэр, орон сууц | 1 470 | 1 331 | 1 203 | 90.4 |
| Аюулт үзэгдлийн улмаас хорогдсон, устгасан мал, тэжээвэр амьтан, толгой | 14 662 | 163 754 | 1 048 355 | 6.4** |
| Объектын түймэр | 2 901 | 3 406 | 2 823 | 82.9 |
| Учирсан хохирлын хэмжээ, тэрбум төг | 15.0 | 49.3 | 25.9 | 52.5 |

** Засгийн газрын тохируулагч агентлаг Онцгой байдлын ерөнхий газрын мэдээлэл*
*** Дахин их*

## I.6 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2016 оны эхний 9 сард 21105 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 129 буюу 0.6 хувиар өсчээ.

Зураг I.12

**Бүртгэгдсэн гэмт хэрэг,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэрэг өсөхөд өмчлөх эрхийн эсрэг (416), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (394) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2016 оны 9 дүгээр сард 2329 болж, өмнөх сарынхаас 12 буюу 0.5 хувиар өсчээ.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 11561 хэргийн 7004 буюу 60.6 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 0.2 пункт, нийслэлийн хэмжээнд 0.9 пунктээр өссөн байна.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2016 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 152 буюу 18.6 хувь, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 423 буюу 25.6 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 185 буюу 6.5 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 201 буюу 4.6 хувиар буурчээ.

18, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэрэг 2016 оны эхний 9 сард улсын дунджаар 108 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 буюу 1.9 хувиар нэмэгдсэн байна.

Гэмт хэргийн улмаас 8539 хүн гэмтэж, 725 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүн 254 буюу 3.1 хувь, нас барсан хүн 2 буюу 0.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг I.13

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүн,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны эхний 9 сард 139.0 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 31.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 24.2 тэрбум төг буюу 21.1 хувиар өсч, харин нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 3.5 тэрбум төг буюу 10.1 хувиар буурсан байна.

Зураг I.14

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирол,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төг




Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 9 дүгээр сард 23.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 14.2 тэрбум төг буюу 2.6 дахин өслөө.

Учирсан хохирлын хэмжээ 9 дүгээр сард өмнөх сарынхаас өсөхөд хилийн чанадад гарсан залилангийн хэргээс үүссэн хохирол нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2016 оны эхний 9 сард 21.4 мянга болж, 1016 буюу 4.7 хувь нь 18 хүртэлх насны хүүхэд, 8750 буюу 40.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Улсын хэмжээгээр 2016 оны эхний 9 сард 65.0 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 4082 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүн 7.9 мянга буюу 10.8 хувь, баривчлагдсан хүн 7.7 мянга буюу 65.3 хувиар буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 1066 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 295 буюу 38.3 хувиар өссөн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг 2016 оны 9 дүгээр сард 83 болж, өмнөх сарынхаас 11 буюу 11.7 хувиар буурсан байна.

Малын хулгайн гэмт хэрэг 620 бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн хэргийн 2.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 281 буюу 31.2 хувиар буурсан байна.

Малын хулгайн хэрэг 2016 оны 9 дүгээр сард 58 болж, өмнөх сарынхаас 7 буюу 13.7 хувиар өссөн байна.

# II. Эдийн засгийн үзүүлэлт

## II.I Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2016 оны 9 дүгээр сарын эцэст 11.4 их наяд төг болж, өмнөх сарынхаас 184.9 тэрбум төг буюу 1.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1515.4 тэрбум төг буюу 15.3 хувиар өсчээ.

Хүснэгт II.1

**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт,**
сарын эцэст, тэрбум төг

| Үзүүлэлт | 2015 | 2016 | |
|---|---|---|---|
| | IX | VIII | IX |
| **Мөнгөний нийлүүлэлт, М2** | **9 934.5** | **11 265.0** | **11 449.9** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | - 1.4 | 13.1 | 15.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар | - 0.3 | - 0.4 | 1.6 |
| **Нийт хадгаламж** | **7 278.3** | **8 113.6** | **8 109.3** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | 4.4 | 12.4 | 11.4 |
| Сарын өөрчлөлт, хувиар | 0.8 | - 1.2 | - 0.1 |
| **Төгрөгийн хадгаламж** | **5 182.9** | **5 573.9** | **5 668.1** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | - 0.7 | 9.8 | 9.4 |
| Сарын өөрчлөлт, хувиар | 2.1 | - 2.8 | 1.7 |
| **Валютын хадгаламж** | **2 095.4** | **2 539.7** | **2 441.2** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | 19.3 | 18.5 | 16.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар | - 2.2 | 2.7 | - 3.9 |

Мөнгөний нийлүүлэлт 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 184.8 тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж, хадгаламжийн байгууллагаас гадуурхи мөнгө нийтдээ 121.4 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч валютын харилцах, төгрөгийн хадгаламж, төгрөгийн харилцах, 306.2 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөллөө.

Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө 2016 оны 9 дүгээр сарын эцэст 795.8 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 21.4 тэрбум төг буюу 2.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 27.9 тэрбум төг буюу 3.6 хувиар өсчээ.

Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2016 оны 9 дүгээр сарын эцэст 2302.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 139.7 тэрбум төг буюу 5.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 657.3 тэрбум төг буюу 40.0 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 9 дүгээр сарын эцэст 12.4 их наяд төг болж, өмнөх сарынхаас 50.5 тэрбум төг буюу 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 470.3 тэрбум төг буюу 3.9 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2016 оны 9 дүгээр сарын эцэст 782.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 45.8 тэрбум төг буюу 5.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 46.4 тэрбум төг буюу 5.6 хувиар буурчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.3 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.4 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.6 пунктээр буурчээ.

Зураг II.1

**Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг**




Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2016 оны 9 дүгээр сарын эцэст 1036.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 20.8 тэрбум төг буюу 2.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 183.8 тэрбум төг буюу 21.6 хувиар өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 8.4 хувийг эзэлж, өмнөх сарынхаас 0.2 пунктээр буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1.3 пунктээр нэмэгдсэн байна.

Үнэт цаасны арилжаагаар 2016 оны эхний 9 сард 214.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 54.6 сая ш үнэт цаас арилжсан нь өмнөх оны мөн үеийнхээс гүйлгээ 543.3 тэрбум төг буюу 71.7 хувиар буурч, үнэт цаас 29.8 сая ш буюу 2.2 дахин өссөн байна. Харин 2016 оны 9 дүгээр сард 53.6 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 4.2 сая ш үнэт цаас арилжсан нь өмнөх сарынхаас гүйлгээ 52.6 тэрбум төг буюу 51.3 дахин, арилжсан үнэт цаас 3.5 сая ш буюу 5.6 дахин өсчээ.

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 2016 оны эхний 9 сард 66.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 280.9 тэрбум төг буюу 80.9 хувиар буурсан байна.

Харин 2016 оны 9 дүгээр сард 1.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдсэн нь өмнөх сарынхаас 1.1 тэрбум төг буюу 2.5 дахин өсчээ.

Хөрөнгийн зах зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2016 оны 9 дүгээр сард 11539.1 нэгж болж, өмнөх сарынхаас 919.6, өмнөх оны мөн үеийнхээс 1671.1 нэгжээр буурчээ.

Зураг II.2

**ТОП-20 индекс,** сарын дундаж, нэгжээр



Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2016 оны 9 дүгээр сард 1387.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 30.8 тэрбум төг буюу 2.2 хувиар буурчээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2016 оны 9 дүгээр сард 2243.98 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 250.19 төг буюу 12.5 хувиар суларчээ. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өмнөх сарынхаас 2016 оны 8 дугаар сард 7.7 хувь, 9 дүгээр сард 2.5 хувиар суларсан байна.

Төгрөгийн юаньтай харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2016 оны 9 дүгээр сард 336.29 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 23.24 төг буюу 7.4 хувиар суларсан байна. Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш өмнөх сарынхаас 2016 оны 8 дугаар сард 8.1 хувь, 9 дүгээр сард 2.2 хувиар суларсан байна.

Төгрөгийн рубльтэй харьцах, Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2016 оны 9 дүгээр сард 34.81 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4.94 төг буюу 16.5 хувиар суларсан байна. Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш өмнөх сарынхаас 2016 оны 8 дугаар сард 6.9 хувь, 9 дүгээр сард 3.3 хувиар суларсан байна.

Хүснэгт II.2

**Валютын ханш**

Төгрөгийн валюттай харьцах, Монголбанкны нэрлэсэн ханш, сарын дундаж, төг

| Үзүүлэлт | 2015 | 2016 | |
|---|---|---|---|
| | IX | VIII | IX |
| **Ам. доллар** | **1 993.79** | **2 189.05** | **2 243.98** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | 8.6 | 10.0 | 12.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар | 0.2 | 7.7 | 2.5 |
| **Евро** | **2 240.06** | **2 453.43** | **2 515.86** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | - 5.5 | 10.6 | 12.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар | 1.0 | 9.2 | 2.5 |
| **Юань** | **313.05** | **329.20** | **336.29** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | 4.7 | 4.9 | 7.4 |
| Сарын өөрчлөлт, хувиар | - 0.2 | 8.1 | 2.2 |
| **Рубль** | **29.87** | **33.68** | **34.81** |
| Жилийн өөрчлөлт, хувиар | - 38.2 | 10.9 | 16.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар | - 1.6 | 6.9 | 3.3 |

## II.2 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2016 оны эхний 9 сард 4012.7 тэрбум төг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 6064.4 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 2051.7 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеийнхээс 1184.4 тэрбум төгрөгөөр өсөхөд орлого 0.8 хувиар буурч, зарлага 23.4 хувиар нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Зураг II.3

**Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төг




Татварын нийт орлого 3514.4 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 14.5 тэрбум төг буюу 0.4 хувиар өсөхөд бусад татвар төлбөр хураамжийн орлого 177.8 тэрбум төг буюу 32.7 хувь, гадаад үйл ажиллагааны орлого 8 тэрбум төг буюу 3.3 хувиар буурсан хэдий ч нийгмийн даатгалын орлого 84.1 тэрбум төг буюу 11.1 хувь, онцгой албан татвар 82.2 тэрбум төг буюу 20.0 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 15.5 тэрбум төг буюу 2.0 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2016 оны 8 дугаар сард 165.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан бол 2016 оны 9 дүгээр сард 243.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 87.6 хувийг татварын орлого, 12.4 хувийг татварын бус орлого эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс татварын орлого 1.1 пунктээр өсч, татварын бус орлого 1.1 пунктээр буурсан байна (Хавсралт 8).

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2016 оны эхний 9 сард 6064.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1151.2 тэрбум төг буюу 23.4 хувиар өсөхөд урсгал зардал 606.3 тэрбум төг буюу 15.0 хувиар, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 472.9 тэрбум төг буюу 23.4 дахин өссөн нь нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 76.5 хувь, хөрөнгийн зардал 15.4 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 8.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс урсгал зардлынх 5.5 пункт, хөрөнгийн зардлынх 2.1 пунктээр буурч, эргэж төлөгдөх цэвэр зээл 7.7 пунктээр өссөн байна.

## II.3 Гадаад худалдаа

Монгол Улс 2016 оны эхний 9 сард дэлхийн 155 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5780.8 сая ам.долл, үүнээс экспорт 3332.8 сая ам.долл, импорт 2448.0 сая ам.доллар байна.

Зураг II.4

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, сая ам.долл




Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс 616.9 сая ам.долл буюу 9.6 хувь, үүнээс экспорт 208.1 сая ам.долл буюу 5.9 хувь, импорт 408.8 сая ам.долл буюу 14.3 хувиар буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2015 оны эхний 9 сард 684.2 сая ам.долларын ашигтай гарч байсан бол 2016 оны эхний 9 сард өмнөх оны мөн үеийнхээс 200.7 сая ам.доллараар нэмэгдэж, 884.8 сая ам.долларт хүрчээ.

Экспорт өмнөх оны мөн үеийнхээс 208.1 сая ам.долл буюу 5.9 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний экспорт 387.5 сая ам.долл, үүнээс зэсийн баяжмал 441.8 сая ам.долл, боловсруулаагүй нефть 56.5 сая ам.доллараар, нэхмэл, нэхмэл бүтээгдэхүүн 8.9 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн хэдий ч үнэт чулуу, металл, алтны экспорт 115.2 сая ам.долл, нүүрсний экспорт 76.9 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт II.3

**Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн,**
жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мян.т

| | 2015 I-IX | 2016* I-IX | 2016* I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|
| Нүүрс | 10 504.0 | 16 245.6 | 154.7 |
| Зэсийн баяжмал | 1 059.8 | 1 205.9 | 113.8 |
| Төмрийн хүдэр, баяжмал | 3 423.9 | 4 240.9 | 123.9 |
| Боловсруулаагүй газрын тос, мян.барр | 5 856.7 | 5 916.8 | 101.0 |
| Цайрын хүдэр, баяжмал | 78.1 | 97.8 | 125.2 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт, т | 7.6 | 9.8 | 129.9 |

** Урьдчилан гүйцэтгэл*

Импорт өмнөх оны мөн үеийнхээс 408.8 сая ам.долл буюу 14.3 хувиар буурахад эрдэс бүтээгдэхүүний импорт 215.0 сая ам.долл, үүнээс дизелийн түлш 126.5 сая ам.долл, автобензин 69.0 сая ам.доллараар, үндсэн төмөрлөг бүтээгдэхүүнийх 134.4 сая ам.долл, машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийнх 65.6 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлжээ.

Эрдэс бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 84.4 хувийг эзэлж байгаа бол импортын 53.9 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд ангийн импорт эзэлж байна.

## II.4 Үнэ

### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.1 хувиар буурсан бол, өмнөх оны эцсийнхээс 0.6 хувиар өслөө.

Зураг II.5

**Хэрэглээний үнийн улсын индекс**
**(өмнөх оны 12 сар =100)**




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 0.1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 9 дүгээр сард өмнөх оны эцсийнхээс 0.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 2.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.6 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.8 хувь, үүнээс төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дүнгээрээ 11.9 хувь, мах, махан бүтээгдэхүүнийх 7.1 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

Хүснэгт II.4

**Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс,**
2016 оны 9 дүгээр сард

хувь

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | 2016 IX / 2015 IX | 2016 IX / 2015 XII | 2016 IX / 2016 VIII |
|---|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **100.0** | **99.9** | **100.6** | **99.4** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 29.3 | 97.2 | 102.7 | 97.2 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.2 | 102.4 | 102.6 | 100.9 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.1 | 101.9 | 100.3 | 100.2 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 12.3 | 99.5 | 95.7 | 100.4 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.7 | 101.5 | 100.9 | 99.8 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 105.5 | 104.8 | 100.7 |
| Тээвэр | 12.2 | 98.5 | 98.3 | 100.1 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 100.0 | 100.2 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.8 | 99.7 | 99.4 | 100.0 |
| Боловсролын үйлчилгээ | 4.7 | 102.5 | 102.5 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.6 | 100.6 | 100.3 | 100.1 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.1 | 101.7 | 101.3 | 100.3 |

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас Орхон, Өвөрхангай, Ховд, Дархан-Уул, Говьсүмбэр аймагт 0.1-1.2 хувиар өсч, бусад 16 аймагт 0.1-2.3 хувиар буурчээ. Говьсүмбэр аймагт 1.2 хувиар өсч, Говь-Алтай аймагт 2.3 хувиар буурсан нь хамгийн өндөр үзүүлэлт байна.

Зураг II.6

**Хэрэглээний үнийн индекс,** хувь, аймаг, нийслэлээр 2016 оны 9 дүгээр сард (өмнөх сар = 100%)




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурсан бол өмнөх оны эцсийнхээс 0.1 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2016 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 1.5 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин өмнөх сарынхаас 0.9 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, үүнээс төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дүнгээрээ 9.2 хувь, мах, махан бүтээгдэхүүнийх 8.4 хувиар буурсан нь голлон нөлөөллөө.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод өмнөх оны жилийн эцсийнхээс 0.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.1 хувь, боловсролын үйлчилгээнийх 2.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээнийх хувь 6.9 хувь, согтууруулах ундаа, тамхиных 4.4 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Улаанбаатар хотод 2016 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 12.5 хувийнх нь үнэ өсч, 9.7 хувийнх нь буурч, 77.8 хувийнх нь үнэ тогтвортой байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 28.0 хувь буюу 26 нэрийн барааны үнэ нэмэгджээ.




## Орон сууцны үнийн индекс

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт орон сууцны үнийн индекс 2016 оны 3 дугаар улиралд 2010 оны эцсийнхээс 84.5 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 8.3 хувиар, өмнөх улирлынхаас 2.6 хувиар буурсан байна.

Орон сууцны үнийн индекс 2016 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс Сүхбаатар дүүрэгт 5.5 хувь, Чингэлтэй болон Хан-Уул дүүрэгт 6.1 хувь, Баянзүрх дүүрэгт 7.3 хувь, Баянгол дүүрэгт 9.5 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 11.9 хувиар, харин

өмнөх улирлынхаас Баянгол болон Хан-Уул дүүрэгт 2.4 хувь, Баянзүрх дүүрэгт 2.5 хувь, Сүхбаатар дүүрэгт 2.7 хувь, Чингэлтэй дүүрэгт 2.8 хувь, Сонгинохайрхан дүүрэгт 2.9 хувиар буурсан байна.

1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2016 оны 3 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 6 дүүрэгт 3.6-7.8 хувиар, 1970-2001 оны орон сууцных 4.8-11.8 хувиар, 2002 оноос хойш ашиглалтад оруулсан орон сууцных 6.2-14.7 хувиар буурсан байна.

Зураг II.7

**Улаанбаатар хотын орон сууцны үнийн индекс, хувиар,** 2016 оны 3 дугаар улиралд, өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулснаар




1970 оноос өмнө ашиглалтад оруулсан орон сууцны үнийн индекс 2016 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 6 дүүрэгт 2.1-4.2 хувиар, 1970-2001 оны орон сууцных 2.2-3.5 хувиар, 2002 оноос хойших орон сууцны үнийн индекс 1.9-4.5 хувиар буурчээ.

Зураг II.8

**Улаанбаатар хотын орон сууцны үнийн индекс, хувиар,** 2016 оны 3 дугаар улиралд, өмнөх улирлынхтай харьцуулснаар




## Хөдөө аж ахуйн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2016 оны 9 дүгээр сард үхрийн 2 метрээс дээш урттай ширний дундаж үнэ Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Архангай, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий аймагт хамгийн бага буюу 15.0-20.0 мянган төгрөг; Дорнод, Орхон, Төв, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 23.0-30.0 мянган төгрөг байна. Харин адууны ширний үнэ Баянхонгор, Говьсүмбэр, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод, Завхан, Орхон аймагт хамгийн бага буюу 10.0-20.0 мянган төгрөг; Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, аймаг, Улаанбаатар хот, Говь-Алтай аймагт хамгийн их буюу 30.0-40.0 мянган төгрөг; ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Сүхбаатар, Хөвсгөл, Архангай, Булган, Орхон, Дорнод аймагт хамгийн бага буюу 30.0-40.0 мянган төгрөг; Завхан, Өмнөговь аймаг, Улаанбаатар хот, Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай аймагт хамгийн их буюу 45.0-50.0 мянган төгрөг байна.

## II.5 Статистикийн бизнес регистрийн сан

Монгол Улсын “Статистикийн тухай” хуули Статистикийн бизнес регистрийн санд 2016 оны эхний 9 сарын байдлаар 138.7 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 69.5 мянга буюу 50.1 хувь нь үйл ажиллагаа явуулж байна. Регистрийн санд бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 44.0 мянга буюу 63.2 хувь нь Улаанбаатар хотод байна. Үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын 83.6 хувь нь 1-9 ажиллагчидтай, 7.2 хувь нь 10-19 ажиллагчидтай, 5.7 хувь нь 20-49 ажиллагчидтай, 3.5 хувь нь 50-иас дээш ажиллагчидтай байна.

Үйл ажиллагаа явуулаагүй 69.2 мянган аж ахуйн нэгж, байгууллагын 29.7 мянга буюу 42.9 хувь нь үйл ажиллагаагаа эхлээгүй, 35.3 мянга буюу 50.8 хувь нь түр зогсоосон, 1.5 мянга буюу 2.2 хувь нь бүрэн зогсоосон, 2.6 мянга буюу 4.1 хувь нь хаяг тодорхойгүй болон бусад шалтгаантай байна. Өмнөх оны мөн үеийнхээс үйл ажиллагаа эхлээгүй аж ахуйн нэгж, байгууллагын эзлэх хувь 7.9 пунктээр нэмэгдэж, түр зогсоосон аж ахуйн нэгж, байгууллагынх 6.3 пунтээр буурчээ.

## II.6 Хөдөө аж ахуй

### Мал аж ахуй

Улсын хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны 23.9 сая хээлтэгч малын 19.7 сая буюу 82.5 хувь нь 2016 оны эхний 9 сард төллөсөн байна. Эм хонины 86.4 хувь, эм ямааны 80.9 хувь, үнээний 74.7 хувь, гүүний 68.9 хувь, ингэний 46.8 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 97.3 хувь буюу 19.2 сая төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 353.5 мянга буюу 1.9 хувиар өссөн байна.

Зураг II.9

**Төллөсөн хээлтэгч,** аймаг, нийслэлээр, 2016 оны эхний 9 сарын байдлаар, мян.толгой




Энэ оны 3 дугаар улиралд 181.2 мянган хээлтэгч төллөсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 55.9 мянга буюу 44.6 хувиар нэмэгдсэн байна. Харин бойжуулсан төл 164.1 мянга болж өмнөх оны мөн үеийнхээс 52.5 мянга буюу 47.1 хувиар өсчээ.

Зураг II.10

**Бойжуулсан төл, төрлөөр,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мян.толгой




Том малын зүй бус хорогдол 2016 оны эхний 9 сард улсын хэмжээнд 1263.2 мян. толгой болж, өмнөх оны мөн үеийнхээс 789.1 мянга буюу 2.7 дахин өссөн байна. Том малын зүй бус хорогдлыг малын төрлөөр авч үзвэл, адуу 53.7 мянга, үхэр 121.1 мянга, тэмээ 0.8 мянга, хонь 463.2 мянга, ямаа 624.5 мянга байна. Нийт хорогдлын 36.7 хувийг хонь, 49.4 хувийг ямаа эзэлж байна.

Өвчнөөр хорогдсон мал 2016 оны эхний 9 сард 46.6 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 19.1 мянга буюу 69.6 хувиар өсчээ.

Зураг II.11

**Зүй бусаар хорогдсон том мал,** аймаг, нийслэлээр, 2016 оны эхний 9 сарын байдлаар, мян.толгой




Энэ оны 3 дугаар улиралд том малын зүй бус хорогдол 26.6 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 15.9 мянга буюу 37.4 хувиар буурч, харин өвчнөөр хорогдсон мал 14.3 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 11.6 мянга буюу 5.3 дахин өссөн байна.

Зураг II.12

**Зүй бусаар хорогдсон том мал, төрлөөр** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мян.толгой



## Газар тариалан

Ургац хураалтын явцын мэдээгээр улсын хэмжээнд 2016 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 292.1 мянган тонн үр тариа, 122.0 мянган тонн төмс, 69.7 мянган тонн хүнсний ногоо хурааж, 902.0 мянган тонн өвс хадлан, 19.1 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеэс үр тариа 196.7 мянган тонн буюу 3.1 дахин, өвс хадлан 110.5 мянган тонн буюу 14.0 хувь, хүнсний ногоо 16.0 мянган тонн буюу 29.9 хувь, төмс 0.9 мянган тонн буюу 0.8 хувь, гар тэжээл 0.4 мянган тонн буюу 2.1, дарш 0.3 мянган тонн буюу 86.3 хувиар өссөн байна.

Зураг II.13

**Хураасан ургац,** бэлтгэсэн өвс хадлан, гар тэжээл жил бүрийн 10 дугаар сарын 1-ний байдлаар, мянган тонн




## II.7 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 9 сард 6828.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 415.0 тэрбум төг буюу 6.5 хувиар өслөө. Үүнд боловсруулах аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 165.8 тэрбум төг буюу 10.5 хувиар буурсан хэдий ч уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл 486.8 тэрбум төг буюу 11.3 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

Хүснэгт II.5

**Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар

| Аж үйлдвэрийн салбар | 2015 | | 2016 | | 2016* I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|---|
| | IX | I-IX | IX | I-IX | |
| Нийт дүн | 823.6 | 6 413.3 | 878.2 | 6 828.3 | 106.5 |
| Уул уурхай, олборлох аж үйлдвэр | 584.1 | 4 310.8 | 656.9 | 4 797.6 | 111.3 |
| Боловсруулах аж үйлдвэр | 183.8 | 1 579.9 | 164.7 | 1 414.1 | 89.5 |
| Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж | 55.7 | 522.6 | 56.6 | 616.6 | 118.0 |

** Урьдчилсан гүйцэтгэл*

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс (улирлын нөлөөллийг арилгасан туршилт тооцоо) 2016 оны 9 дүгээр сард 137.4 (2010=100) болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.4 хувь, жилийн эцсийнхээс 5.0 хувиар өсч, харин өмнөх сарынхаас 7.5 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн индекс өмнөх сарынхаас 7.5 хувиар буурахад уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар 7.6 хувиар буурсан нь голлон нөлөөллөв.

Өмнөх оны мөн үеийнхээс уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт төмрийн хүдэр, молибдений баяжмал, цайрын баяжмал, зэсийн баяжмал, нүүрс, алт зэрэг бүтээгдэхүүний олборлолт 0.5-39.9 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт цэвэр ус, нарийн боов, шингэн сүү, тамхи, бууз, банш, архи, амтат ус, ундаа, хэвлэмэл хуванцар картууд, хиаман төрлийн бүтээгдэхүүн, төмөр замын дэр мод зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.7 хувиас 1.5 дахин өссөн байна.

Харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт газрын тос, хайлуур жонш, буталмал чулуу зэрэг бүтээгдэхүүний олборлолт 4.4-39.0 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт шар айраг, спирт, катодын зэс, талх, цемент, зүсмэл материал, шохой, барилгын модон хаалга, цонх, төмөр бетон эдлэл, ган төмөр хийц, вакуум цонх, хаалга, металл бэлдэц, металл цувимал зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.7-65.6 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2016 оны эхний 9 сард 7647.9 тэрбум төг болж, 4670.8 тэрбум төг буюу 61.1 хувийг гадаад зах зээлд борлуулжээ.

Зураг II.14

**Аж үйлдвэрийн салбарын борлуулалт,** дэд салбараар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар



## II.8 Барилга

Барилгын байгууллагууд 2016 оны эхний 9 сард нийт 1153.4 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил гүйцэтгэсэн байна. Нийт барилга угсралт, их засварын ажлын 98.1 хувь буюу 1131.9 тэрбум төгрөгийн ажлыг дотоодын барилгын байгууллагууд, 1.9 хувь буюу 21.5 тэрбум төгрөгийн гадаадын барилгын байгууллагууд гүйцэтгэжээ.

Дотоодын барилгын байгууллагуудын гүйцэтгэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 329.9 тэрбум төгрөг буюу 22.6 хувиар буурсан нь нийт барилга угсралт, их засварын хэмжээ өмнөх оноос 348.6 тэрбум төгрөгөөр буюу 23.2 хувиар буурахад нөлөөлсөн байна.

Барилга угсралт, их засварын ажлын 44.2 хувийг нь орон сууцны барилга, 31.3 хувийг нь орон сууцны бус барилга, 22.1 хувийг нь инженерийн барилга, байгууламж, 2.4 хувийг нь их засварын ажил эзэлж байна. Өмнөх оны мөн үеэс орон сууцны бус барилгын ажлын эзлэх хувь 4.4 пункт, орон сууцны барилгынх 2.0 пунктээр нэмэгдэж, инженерийн барилга, байгууламжийнх 6.0 пункт, их засварын ажлынх 0.4 пунктээр буурсан байна.

Зураг II.15

**Барилга угсралт, их засварын ажил, жил бүрийн эхний 9 сард, тэрбум төг**




Барилга угсралт, их засварын ажлын хэмжээ 2016 оны 3 дугаар улиралд 526.9 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеэс 348.4 тэрбум төг буюу 39.8 хувиар буурчээ.

## II.9 Тээвэр

Бүх төрлийн тээврээр 2016 оны эхний 9 сард 30.5 сая тонн ачаа, давхардсан тоогоор 195.2 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 3.0 сая тонн буюу 10.8 хувь өссөн бол зорчигчид 13.3 сая хүн буюу 6.4 хувиар буурчээ.

Харин бүх төрлийн тээврээр 2016 оны 3 дугаар улиралд 14.3 сая тонн ачаа, 61.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх улирлаас тээсэн ачаа 5.0 сая тонн буюу 50.8 хувиар өсч харин зорчигчид 18.5 сая хүн буюу 23.1 хувиар буурчээ.

Авто тээврээр 2016 оны эхний 9 сард 16.3 сая тонн ачаа, давхардсан тоогоор 192.7 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 2.6 сая тонн буюу 19.2 хувь өсч харин зорчигчид 13.2 сая хүн буюу 6.4 хувиар буурчээ.

Авто тээврийн орлого 2016 оны эхний 9 сарын байдлаар 374.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 14.5 тэрбум төг буюу 4.0 хувиар өссөн байна.

Харин авто тээврээр 2016 оны 3 дугаар улиралд 9.2 сая тонн ачаа, 60.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх улирлаас тээсэн ачаа 4.7 сая тонн буюу 2.1 дахин өсч харин зорчигчид 18.6 сая хүн буюу 23.5 хувиар буурчээ.

Төмөр замын тээврээр 2016 оны эхний 9 сард 14191.0 мян.тонн ачаа, давхардсан тоогоор 1995.5 мян.хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 346.1 мян.тонн буюу 2.5 хувиар өсч, харин зорчигчид 179.6 мян.хүн буюу 8.3 хувиар буурсан байна.

Төмөр замаар тээсэн нийт ачаанд 2016 оны эхний 9 сард дотоодын ачаа 41.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 6.4 пунктээр буурахад барилгын материалын тээвэрлэлт 679.0 мян.тонн буюу 43.3 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Зураг II.16

**Төмөр замын тээврээр зорчигчид,** тээсэн ачаа, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




Нийт тээсэн ачаанд экспортын ачаа 35.4 хувь, импортынх 10.7 хувь, дамжин өнгөрсөн ачааных 12.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс экспортын ачааных 6.4 пункт, дамжин өнгөрсөн ачааных 1.5 пунктээр нэмэгдэж, харин импортынх 1.4 пунктээр буурсан байна.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2016 оны эхний 9 сард 315.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 31.4 тэрбум төг буюу 11.1 хувиар өсчээ.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2016 оны 9 дүгээр сард 1741.9 мян.тонн болж, өмнөх сарынхаас тээсэн ачаа 22.1 мян.тонн буюу 1.3 хувь өссөн бол зорчигчид 190.2 мян.хүн болж, 60.8 мян.хүн буюу 24.2 хувиар буурч, орлого 42.7 тэрбум төгрөг болж, 3.6 тэрбум төг буюу 9.3 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2016 оны эхний 9 сард 2265.1 тонн ачаа, давхардсан тоогоор 520.5 мян.хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 141.5 тонн буюу 6.7 хувь, зорчигчид 33.7 мян.хүн буюу 6.9 хувиар өссөн байна.

Агаарын тээврээр 2016 оны эхний 9 сард дотоодод зорчигчид 172.9 мян.хүн болж, өмнөх оны мөн үеийнхээс 25.8 мян.хүн буюу 17.5 хувиар, олон улсад зорчигчид 347.6 мян.хүн болж, 8.0 мян.хүн буюу 2.3 хувиар өсөв.

Агаарын тээврийн салбарын орлого 2016 оны эхний 9 сард 223.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 21.5 тэрбум төг буюу 10.7 хувиар өсчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2016 оны 9 дүгээр сард 252.0 тонн болж, өмнөх сарынхаас 39.5 тонн буюу 13.5 хувь, зорчигчид 60.6 мян.хүн болж, 32.8 мян.хүн буюу 35.1 хувь, орлого 24.2 тэрбум төг болж, 17.2 тэрбум төг буюу 41.5 хувиар буурсан байна.

Зураг II.17

**Агаарын тээврээр зорчигчид,** тээсэн ачаа, жил бүрийн эхний 9 сарын байдлаар




## Шуудан, холбоо

Шуудан, холбооны салбарын орлого 2016 оны эхний 9 сард 572.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 22.2 тэрбум төгрөг буюу 4.0 хувиар нэмэгджээ. Харин 2016 оны 3 дугаар улиралд 208.6 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 14.3 тэрбум буюу 7.4 хувиар өссөн байна.

Хүснэгт II.6

Шуудан, холбооны салбарын нийт орлого, тэрбум төг

| Үзүүлэлт | 2015 | | 2016 | | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|---|
| | VII-IX | I-IX | VII-IX | I-IX | |
| Нийт орлого, оны үнээр | 195.6 | 549.8 | 208.6 | 572.0 | 104.0 |
| Хүн амаас орсон орлого | 144.9 | 415.4 | 157.7 | 412.6 | 99.3 |

Хүн амаас орсон шуудан, холбооны үйлчилгээний орлого 2016 оны эхний 9 сард 412.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 2.9 тэрбум төгрөг буюу 0.7 хувиар буурчээ.

Нийт орлогод хүн амаас орсон орлого 72.1 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 3.5 пунктээр буурчээ.

Суурин утасны цэг 2016 оны эхний 9 сард 267.3 мян.ширхэг болж, өмнөх оны мөн үеийнхээс 17.6 мян.ширхэг буюу 7.1 хувиар өсчээ. Үүнд гурвалсан үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хэрэглэгчдийн тоо нэмэгдсэн нь голлон нөлөөлөв.

Үүрэн утас хэрэглэгчид 2016 оны эхний 9 сард давхардсан тоогоор 3460.4 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 432.1 мянга буюу 11.1 хувиар буурчээ.

Хүснэгт II.7

**Шуудан, холбооны салбарын үндсэн үзүүлэлт,** жил жил бүрийн эхний 9 сарын байдлаар

| | 2015 I-IX | 2016 I-IX | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|
| Нийт орлого | **549 841.2** | **572 008.3** | **104.0** |
| Хүн амаас орсон орлого | 415 436.8 | 412 518.1 | 99.3 |
| Суурин утасны цэг, мян.ш | 249.7 | 267.3 | 107.1 |
| Утасгүй холбоо | 580 | 538 | 92.8 |
| Үүрэн утас хэрэглэгчид, мян.хүн (давхардсан тоогоор) | 3 892.5 | 3 460.4 | 88.9 |
| Кабелийн телевиз хэрэглэгчид | 369 344 | 394 768 | 106.9 |
| Шуудангийн үйлчилгээний үзүүлэлт | | | |
| Хүргэсэн бичиг, захидал, мян.ш | 863.3 | 1 207.6 | 139.9 |
| Хүргэсэн илгээмж, мян.ш | 208.0 | 144.0 | 69.2 |
| Хүргэсэн хэвлэл, мян.ш | 6 150.1 | 5 283.8 | 85.9 |

Харин кабелийн телевиз хэрэглэгчид 394.8 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 25.4 мянга буюу 6.9 хувиар нэмэгдсэн байна.

Шуудангийн үйлчилгээний салбар 2016 эхний 9 сард 1207.6 мян.ширхэг бичиг, захидал, 144.0 мян.ширхэг илгээмж, 5283.8 мян.ширхэг тогтмол хэвлэлийг хэрэглэгчдэд хүргэжээ. Өмнөх оны мөн үеийнхээс бичиг захидал 344.3 мян.ширхэг буюу 39.9 хувиар өсч харин хүргэсэн илгээмж 64.0 мян.ширхэг буюу 30.8 хувь, хэвлэл 866.3 мян.ширхэг буюу 14.1 хувиар буурсан байна.

## II.10 Хилээр нэвтэрсэн зорчигчид

Манай улсын хилээр 2016 оны эхний хагас жил Манай улсын хилээр 2016 оны эхний 9 сард давхардсан тоогоор 4055.5 мянган зорчигч нэвтэрсэн нь өмнөх оны мөн үеэс 388.6 мян.хүн буюу 10.6 хувиар өсчээ. Улсын хилээр нэвтэрсэн зорчигчдын 34.8 хувь нь Замын-Үүд, 18.2 хувь нь Алтанбулаг, 16.6 хувь нь Буянт-Ухаа, 8.7 хувь нь Гашуун сухайт, 5.2 хувь нь Шивээ хүрэн, 16.5 хувь нь бусад боомтоор нэвтэрсэн байна.

Зураг II.18

**Монгол Улсын хилийн боомтуудаар нэвтэрсэн зорчигчид,** жил бүрийн эхний 9 сарын байдлаар, мян.хүн




Энэ оны эхний 9 сард улсын хилээр гадаадын 377.4 мян.хүн орсон нь өмнөх оны мөн үеийнхээс 3.9 мянга буюу 1.0 хувиар буурчээ. Тэдний 83.8 хувь нь 30 хүртэл хоног, 3.3 хувь нь 90 хүртэл хоног, 12.9 хувь нь 90, түүнээс дээш хоногийн хугацаагаар ирсэн байна. Гадаадын зорчигчдын 325.0 мянга нь буюу 86.1 хувь нь аялал жуулчлалын зорилгоор хилээр орсон нь өмнөх оны мөн үеийнхээс 2.5 хувиар өссөн байна.

Хилээр орсон гадаадын зорчигчдын 52.4 мянга буюу 13.9 хувь нь ажиллах, суралцах болон байнга оршин суух зорилгоор иржээ.

Өмнөх оны мөн үеийнхээс Тайваны жуулчдын тоо 36.6 хувиар, БНСУ-ынх 22.3 хувиар, Сингапурынх 19.0 хувиар, Энэтхэг улсынх 18.5 хувиар, Австрали улсынх 15.9 хувиар, Канад улсынх 15.5 хувиар, Франц улсынх 14.3 хувиар, Нидерланд улсынх 13.8 хувиар, ОХУ-ынх 11.6 хувиар өссөн бол Хонгконгийн жуулчид 18.8 хувиар, БНХАУ-ынх 13.9 хувиар, Малайз улсынх 10.4 хувиар буурчээ. Улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 250.4 мянга буюу 66.3 хувь нь эрэгтэйчүүд, 109.3 мянга буюу 29.0 хувь нь эмэгтэйчүүд, 17.7 мянга буюу 4.7 хувь нь хүүхэд байна.

Энэ оны эхний 9 сард улсын хилээр орсон гадаадын зорчигчдын 63.8 хувь нь Зүүн Ази, Номхон далайн бүс нутгаас, 29.5 хувь нь Европоос, 4.9 хувь нь Америк тивээс, 1.8 хувь нь Ойрхи Дорнод, Өмнөд Ази, Африк тивээс иржээ. Хилээр орсон гадаадын зорчигчдын 36.9 хувийг БНХАУ-ын иргэд, 17.6 хувийг ОХУ-ын иргэд, 13.8 хувийг БНСУ-ын иргэд, 4.8 хувийг Япон улсын иргэд, 3.8 хувийг АНУ-ын иргэд, 3.0 хувийг Казахстан улсын иргэд, 20.1 хувийг бусад орны иргэд эзэлж байна.

Зураг II.19

**Монгол Улсын хилийн боомтуудаар орсон гадаадын зорчигчид,** бүс нутгаар, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, дүнд эзлэх хувиар




Энэ оны эхний 9 сард манай улсын давхардсан тоогоор 1657.8 мянган иргэн гадаадад зорчсоноос 1333.6 мянга буюу 80.4 хувь нь хувийн журмаар зорчжээ.

Улсын хилээр 2016 оны эхний 9 сард давхардсан тоогоор 1609.0 мянган тээврийн хэрэгслийг нэвтрүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 282.3 мянга буюу 21.3 хувиар өсч, эдгээрийн 38.9 хувийг ачааны машин, 35.7 хувийг суудлын машин, 22.8 хувийг ачааны вагон, 2.6 хувийг бусад тээврийн хэрэгсэл эзэлж байна . Нийт тээврийн хэрэгслийн 87.8 хувь нь Замын-Үүд, Гашуун сухайт, Алтанбулаг, Шивээ хүрэн, Сүхбаатар боомтоор нэвтэрсэн байна.

Зураг II.20

**Монгол Улсын хилийн боомтуудаар нэвтэрсэн тээврийн хэрэгсэл,** 2016 оны эхний 9 сарын байдлаар, хувиар




МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА А. АРИУНЗАЯА

2016 оны 10 дугаар сарын 11

**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 9 сарын байдлаар**
***MAIN INDICATORS, as of the first 9 months of selected years***

| Үзүүлэлтүүд | *Indicators* | 2015 I-IX | 2016 I-IX | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|
| **Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд** | ***Social statistical indicators*** | | | |
| Төрсөн хүүхэд | *Number of births* | 60 849 | 59 320 | 97.5 |
| Халдварт өвчнөөр өвчлөгчид | *Number of infectious disease cases* | 48 825 | 59 599 | 122.1 |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг | *Number of committed offences* | 20 976 | 21 105 | 100.6 |
| **Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд** | ***Macro economic statistical indicators*** | | | |
| Хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, оны эхнээс, хувиар | *National consumer price index, from the beginning of the year, percent* | 2.6 | 0.6 | - |
| Гүйлгээнд гаргасан бэлэн мөнгө*, 9 дүгээр сарын эцэст, тэрбум төг | *Currency in circulation* average of the September, bln.tog* | 767.9 | 795.8** | 103.6 |
| Мөнгө М1*,9 дүгээр сарын эцэст, тэрбум төг | *Money M1*, end of the September, bln.tog* | 1 613.7 | 1 921.1** | 119.1 |
| Мөнгө М2*, 9 дүгээр сарын эцэст, тэрбум төг | *Money M2* end of the September, bln.tog* | 9 934.5 | 11 449.9** | 115.3 |
| Валютын зах зээлийн нэрлэсэн ханш, 9 дүгээр сарын дундаж, 1 ам.доллар=төгрөг* | *Market exchange rate, end of the September, 1 USD=togrog** | 1 993.8 | 2 243.9 | 112.5 |
| Улсын нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж, тэрбум төг | *Total equilibrated revenue and grants of General Government budget, bln.tog* | 4 045.9 | 4 012.7** | 99.2 |
| Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээл, тэрбум төг | *Total expenditure and net lending of General Government budget, bln.tog* | 4 913.2 | 6 064.4** | 123.4 |
| Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл, тэрбум төг | *Equilibrated overall balance of General Government budget bln.tog* | - 867.3 | -2 051.7** | 2.4*** |
| Экспорт, сая ам.долл | *Exports, mln.USD* | 3 540.9 | 3 332.8** | 94.1 |
| Импорт, сая ам.долл | *Imports, mln.USD* | 2 856.7 | 2 448.0** | 85.7 |
| Гадаад худалдааны тэнцэл, сая ам.долл | *External trade balance,mln.USD* | 684.2 | 884.8** | 129.3 |
| **Эдийн засгийн статистикийн үзүүлэлтүүд** | ***Economic statistical indicators*** | | | |
| Бойжуулсан төл, мян.толгой | *Number of survivals, thous.heads* | 18 822.2 | 19 175.7 | 101.9 |
| Зүй бусаар хорогдсон том мал, мян.толгой | *Natural losses of adult animals, thous.heads* | 474.2 | 1263.2 | 2.7*** |
| Хураасан ургац, жил бүрийн 10 дугаар сарын 1-ний байдлаар, мян.т | *Gross harvested on the 1st of October of selected years, thous.t* | | | |
| -Үр тариа | *-Harvest* | 95.4 | 292.1 | 3.1*** |
| -Төмс | *-Potatoes* | 121.1 | 122.0 | 100.8 |
| -Хүнсний ногоо | *-Vegetables* | 53.7 | 69.7 | 129.9 |
| -Бэлтгэсэн өвс хадлан | *-Hay harvest* | 791.5 | 901.9 | 114.0 |
| -Бэлтгэсэн гар тэжээл | *-Hand made fodder* | 18.7 | 19.1 | 102.3 |
| Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл, дэд салбараар, тэрбум төг | *Gross industrial output, by divisions, bln.tog* | 6 413.3 | 6 828.3** | 106.5 |
| Үүнээс: | *Of which:* | | | |
| -Уул уурхай, олборлох аж үйлдвэр | *-Mining and quarrying* | 4 310.8 | 4 797.6** | 111.3 |
| -Боловсруулах аж үйлдвэр | *-Manufacturing* | 1 579.9 | 1 414.1** | 89.5 |
| -Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж | *-Electricity, thermal energy and water supply* | 522.6 | 616.6** | 118.0 |
| Барилга угсралт, их засварын ажил, тэрбум төг | *Total amount construction and capital repair, maintenance, bln.tog* | 1 502.1 | 1 153.4 | 76.8 |
| Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа, мян.т | *Carried freight, by all types of transport, thous.t* | 29 650.5 | 32 770.6 | 110.5 |
| Бүх төрлийн тээврээр зорчигчид (давхардсан тоогоор), сая хүн | *Carried passengers, by all types of transport, mln.persons (double counting)* | 208.6 | 195.2 | 93.6 |

* Эх үүсвэр: Монголбанкны статистикийн сарын мэдээлэл
** Source: Monthly statistical bulletin, Bank of Mongolia*
** Тайлбар: Урьдчилсан гүйцэтгэл
*** Note: Preliminary results*
**** Дахин их*
**** Times more*

# I. ХҮН АМ
# *POPULATION*

1.1. 1000 ХҮНД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЕРДИЙН ЦЭВЭР ӨСӨЛТ, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*BIRTH, DEATH AND NATURAL INCREASE, per 1000 population, by aimags and the capital, as a first 9 months of selected years*

| Аймаг, нийслэл | Төрөлт *Birth* | | | Нас баралт *Death* | | | Ердийн цэвэр өсөлт* *Natural increase** | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| *Aimags and the capital* | 2014 I-IX | 2015 I-IX | 2016 I-IX | 2014 I-IX | 2015 I-IX | 2016 I-IX | 2014 I-IX | 2015 I-IX | 2016 I-IX |
| **Бүгд/*Total*** | **21.5** | **20.4** | **19.5** | **4.3** | **4.1** | **4.0** | **17.2** | **16.3** | **15.5** |
| | **Баруун бүс** | | | | ***Western region*** | | | | |
| БӨ/*BO* | 23.2 | 22.5 | 21.3 | 3.5 | 4.1 | 4.0 | 19.7 | 18.4 | 17.3 |
| ГО/*GO* | 18.4 | 16.9 | 16.1 | 4.4 | 3.8 | 4.3 | 14.0 | 13.1 | 11.8 |
| ЗА/*ZA* | 19.0 | 17.3 | 15.9 | 4.5 | 4.4 | 4.0 | 14.5 | 12.9 | 11.9 |
| УВ/*UV* | 21.7 | 19.9 | 19.1 | 4.6 | 4.4 | 4.4 | 17.1 | 15.5 | 14.7 |
| ХО/*KHO* | 22.7 | 20.8 | 20.2 | 4.1 | 3.9 | 3.4 | 18.6 | 16.9 | 16.8 |
| | **Хангайн бүс** | | | | ***Khangai region*** | | | | |
| АР/*AR* | 19.4 | 16.7 | 16.0 | 3.6 | 3.9 | 3.9 | 15.8 | 12.8 | 12.1 |
| БХ/*BKH* | 20.9 | 18.9 | 17.8 | 4.7 | 4.2 | 4.7 | 16.2 | 14.7 | 13.1 |
| БУ/*BU* | 14.5 | 12.9 | 11.2 | 4.2 | 4.2 | 4.1 | 10.3 | 8.7 | 7.1 |
| ОР/*OR* | 23.3 | 21.5 | 19.5 | 4.5 | 4.2 | 4.0 | 18.8 | 17.3 | 15.5 |
| ӨВ/*OV* | 20.7 | 18.1 | 18.0 | 4.3 | 4.2 | 4.5 | 16.4 | 13.9 | 13.5 |
| ХӨ/*KHS* | 20.9 | 18.7 | 17.5 | 5.3 | 4.7 | 4.7 | 15.6 | 14.0 | 12.8 |
| | **Төвийн бүс** | | | | ***Central region*** | | | | |
| ГС/*GS* | 24.7 | 20.8 | 21.3 | 4.1 | 3.7 | 3.3 | 20.6 | 17.1 | 18.0 |
| ДА/*DA* | 22.3 | 20.3 | 19.0 | 4.5 | 4.2 | 4.1 | 17.8 | 16.1 | 14.9 |
| ДО/*DO* | 17.9 | 18.5 | 16.9 | 4.5 | 3.6 | 4.1 | 13.4 | 14.9 | 12.8 |
| ДУ/*DU* | 19.8 | 16.4 | 16.5 | 4.9 | 4.4 | 4.6 | 14.9 | 12.0 | 11.9 |
| ӨМ/*OM* | 15.6 | 18.0 | 17.0 | 3.4 | 4.0 | 3.9 | 12.2 | 14.0 | 13.1 |
| СЭ/*SE* | 15.1 | 13.7 | 13.6 | 3.5 | 3.7 | 4.1 | 11.6 | 10.0 | 9.5 |
| ТӨ/*TO* | 12.2 | 10.6 | 10.3 | 3.3 | 3.8 | 3.7 | 8.9 | 6.8 | 6.6 |
| | **Зүүн бүс** | | | | ***Eastern region*** | | | | |
| ДД/*DD* | 20.8 | 19.5 | 20.4 | 4.7 | 4.3 | 5.0 | 16.1 | 15.2 | 15.4 |
| СҮ/*SU* | 18.5 | 18.0 | 16.4 | 5.1 | 4.2 | 4.4 | 13.4 | 13.8 | 12.0 |
| ХЭ/*KHE* | 18.2 | 17.8 | 17.2 | 4.2 | 3.5 | 3.7 | 14.0 | 14.3 | 13.5 |
| | **Улаанбаатар** | | | | ***Ulaanbaatar*** | | | | |
| УБ/*UB* | 23.8 | 23.3 | 22.4 | 4.4 | 4.1 | 3.9 | 19.4 | 19.2 | 18.5 |

Тайлбар: * Эрүүл мэндийн яамны төрөлт, нас баралтын мэдээг үндэслэн хүн амын ердийн цэвэр өсөлтийг тооцсон.

*Note: * The natural increase of population has calculated based on birth and death data produced by the Ministry of Health*

# II.Хөдөлмөр
## *Labour*

2.1 ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, ХУРЦ ХОРДЛОГО, бүс, аймаг, нийслэлээр, 2016 оны эхний 9 сарын байдлаар

*OCCUPATIONAL ACCIDENT, ACUTE POISONINGS, by regions, aimags and the capital, as a first 9 months of 2016*

| *Аймаг, нийслэл* | *Aimags and the capital* | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого *Occupational accident, acute poisonings* | | Үүнээс: Осол, хурц хордлогоор *Of wich: Occupational accident and acute poisonings* | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүлэг осол, хурц хордлого *Group accident and acute poisoning* | | Үйлдвэрлэлийн осол *Occupational accident* | | Хурц хордлого *Acute poisonings* | |
| | | VII-IX | I-IX | VII-IX | I-IX | VII-IX | I-IX | VII-IX | I-IX |
| **Бүгд** | ***Total*** | **65** | **191** | **1** | **5** | **64** | **189** | **1** | **2** |
| **Баруун бүс** | ***Western region*** | **9** | **23** | **-** | **2** | **9** | **23** | **-** | **-** |
| Баян-Өлгий | *Bayan-Olgii* | 1 | 7 | - | 1 | 1 | 7 | - | - |
| Говь-Алтай | *Govi-Altai* | 2 | 5 | - | 1 | 2 | 5 | - | - |
| Завхан | *Zavkhan* | 5 | 8 | - | - | 5 | 8 | - | - |
| Увс | *Uvs* | - | 1 | - | - | - | 1 | - | - |
| Ховд | *Khovd* | 1 | 2 | - | - | 1 | 2 | - | - |
| **Хангайн бүс** | ***Khangai region*** | **5** | **31** | **-** | **-** | **5** | **31** | **-** | **-** |
| Архангай | *Arkhangai* | - | 3 | - | - | - | 3 | - | - |
| Баянхонгор | *Bayankhongor* | 2 | 7 | - | - | 2 | 7 | - | - |
| Булган | *Bulgan* | - | 2 | - | - | - | 2 | - | - |
| Орхон | *Orkhon* | 3 | 13 | - | - | 3 | 13 | - | - |
| Өвөрхангай | *Ovorkhangai* | - | 4 | - | - | - | 4 | - | - |
| Хөвсгөл | *Khovsgol* | - | 2 | - | - | - | 2 | - | - |
| **Төвийн бүс** | ***Central region*** | **17** | **40** | **1** | **1** | **17** | **39** | **-** | **1** |
| Говьсүмбэр | *Govisumber* | - | - | - | - | - | - | - | - |
| Дархан-Уул | *Darkhan-Uul* | 4 | 15 | 1 | 1 | 4 | 14 | - | 1 |
| Дорноговь | *Dornogovi* | 1 | 3 | - | - | 1 | 3 | - | - |
| Дундговь | *Dundgovi* | - | - | - | - | - | - | - | - |
| Өмнөговь | *Omnogovi* | 4 | 7 | - | - | 4 | 7 | - | - |
| Сэлэнгэ | *Selenge* | 7 | 8 | - | - | 7 | 8 | - | - |
| Төв | *Tov* | 1 | 7 | - | - | 1 | 7 | - | - |
| **Зүүн бүс** | ***Eastern region*** | **12** | **25** | **-** | **-** | **11** | **24** | **1** | **1** |
| Дорнод | *Dornod* | 1 | 6 | - | - | 1 | 6 | - | - |
| Сүхбаатар | *Sukhbaatar* | 6 | 6 | - | - | 5 | 5 | 1 | 1 |
| Хэнтий | *Khentii* | 5 | 13 | - | - | 5 | 13 | - | - |
| **Улаанбаатар** | ***Ulaanbaatar*** | **20** | **70** | **-** | **2** | **20** | **70** | **-** | **-** |
| **Бусад*** | ***Other**** | **2** | **2** | **-** | **-** | **2** | **2** | **-** | **-** |

Эх үүсвэр: Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улирлын мэдээлэл

*Source: Quarterly report of the Government Regulatory Agency General Agency for specialized inspection*

* - Улаанбаатар төмөр замд гарсан үйлдвэрлэлийн ослыг оруулсан.

* *- Including occupational accidents occurred in the UB railway.*

# III.Боловсрол
# *Education*

## 3.1 БҮХ ШАТНЫ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫГ ТӨГСӨГЧИД
## *3.1 GRADUATES OF EDUCATIONAL INSTITUTIONS FOR ALL LEVELS*

мян.хүн/*thous.persons*

| Сургалтын байгууллагын ангиллаар | *Classification of educational institutions* | Хичээлийн жилээр *By academic years* | | | 2015/2016 / 2014/2015 % |
|---|---|---|---|---|---|
| | | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | |
| **Бүгд** | ***Total*** | **137.4** | **127.7** | **111.8** | **87.5** |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 73.1 | 67.5 | 59.1 | 87.6 |
| Ерөнхий боловсролын сургууль | *General educational schools* | **85.1** | **73.5** | **56.4** | **76.7** |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 43.4 | 37.5 | 29.3 | 78.1 |
| Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв | *Technical and vocational schools* | **18.4** | **19.0** | **19.5** | **102.6** |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 8.0 | 8.1 | 8.0 | 98.8 |
| Их, дээд сургууль, коллеж | *Higher educational institutions (universities, colleges)* | **33.9** | **35.2** | **35.9** | **102.0** |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 21.7 | 21.9 | 21.8 | 99.5 |

## 3.2 ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙГ ӨДРӨӨР СУРАЛЦАН ТӨГСӨГЧИД
## *3.2 NUMBER OF FULL-TIME GRADUATES OF THE GENERAL EDUCATIONAL SCHOOLS*

хүнээр/*persons*

| Аймаг, нийслэл *Aimags and the Capital* | 9-р анги *9th grade* | | | 12-р анги *12th grade* | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Хичээлийн жилээр / *By academic years* | | | | | |
| | 2013/2014 | 2014/2015 | 2015/2016 | 2013/2014* | 2014/2015 | 2015/2016 |
| **Бүгд / *Total*** | **49,900** | **53,752** | **21,149** | **33,992** | **19,213** | **34,809** |
| | **Баруун бүс** | | ***Western region*** | | | |
| **Дүн / *Subtotal*** | **8,075** | **8,739** | **5,206** | **6,168** | **3,523** | **6,321** |
| БӨ/*BO* | 2,049 | 2,307 | 1,590 | 1,911 | 444 | 1,754 |
| ГО/*GO* | 1,148 | 1,174 | 728 | 758 | 592 | 799 |
| ЗА/*ZA* | 1,461 | 1,632 | 587 | 881 | 768 | 1,075 |
| УВ/*UV* | 1,662 | 1,628 | 1,283 | 1,262 | 757 | 1,191 |
| ХО/*KHO* | 1,755 | 1,998 | 1,018 | 1,356 | 962 | 1,502 |
| | **Хангайн бүс** | | ***Khangai region*** | | | |
| **Дүн / *Subtotal*** | **10,882** | **11,825** | **4,273** | **7,440** | **4,600** | **7,400** |
| АР/*AR* | 1,826 | 1,986 | 684 | 1,328 | 718 | 1,360 |
| БХ/*BKH* | 1,722 | 1,851 | 512 | 701 | 780 | 1,115 |
| БУ/*BU* | 926 | 1,083 | 300 | 797 | 406 | 592 |
| ОР/*OR* | 1,835 | 1,683 | 809 | 1,490 | 511 | 1,203 |
| ӨВ/*OV* | 2,142 | 2,314 | 1,182 | 1,467 | 957 | 1,451 |
| ХӨ/*KHS* | 2,431 | 2,908 | 786 | 1,657 | 1228 | 1,679 |
| | **Төвийн бүс** | | ***Central region*** | | | |
| **Дүн / *Subtotal*** | **8,582** | **9,049** | **2,345** | **5,064** | **3,153** | **5,694** |
| ГС/*GS* | 315 | 304 | 80 | 222 | 93 | 274 |
| ДА/*DA* | 1,970 | 1,946 | 508 | 1,298 | 720 | 1,363 |
| ДО/*DO* | 1,095 | 1,208 | 517 | 723 | 378 | 688 |
| ДУ/*DU* | 802 | 798 | 220 | 458 | 339 | 388 |
| ӨМ/*OM* | 1,035 | 1,438 | 200 | 517 | 560 | 681 |
| СЭ/*SE* | 1,981 | 1,901 | 463 | 960 | 708 | 1,360 |
| ТӨ/*TO* | 1,384 | 1,454 | 357 | 886 | 355 | 940 |
| | **Зүүн бүс** | | ***Eastern region*** | | | |
| **Дүн / *Subtotal*** | **3,489** | **4,048** | **987** | **1,514** | **2,013** | **1,727** |
| ДД/*DD* | 1,276 | 1,497 | 434 | 486 | 764 | 948 |
| СҮ/*SU* | 1,013 | 1,053 | 461 | 460 | 523 | 677 |
| ХЭ/*KHE* | 1,200 | 1,498 | 92 | 568 | 726 | 102 |
| | **Улаанбаатар** | | ***Ulaanbaatar*** | | | |
| УБ/*UB* | 18,872 | 20,091 | 8,338 | 13,806 | 5,924 | 13,667 |

* ЕБС-ийн 11 дүгээр ангийг өдрөөр төгсөгчид
** Number of full-time grade 11th graduates of the general educational schools*

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэдээгээр
*Source: Report of the Ministry of Education, Culture, Science and Sports*

3.3 ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖ ТӨГСӨГЧИД, 2015/2016 оны хичээлийн жилээр
*3.3 NUMBER OF GRADUATES OF UNIVERSITIES AND COLLEGES, by academic year 2015/2016*

хүнээр/*persons*

| | | Бүгд *Total* | Диплом *Diploma* | Бакалавр *Bachelor* | Магистрантур *Master* | Докторантур *PhD* |
|---|---|---|---|---|---|---|
| **Төгсөгчид** | ***Graduates*** | **35 889** | **231** | **30 663** | **4 859** | **136** |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 21 848 | 128 | 18 529 | 3 104 | 87 |
| Төрийн өмчийн их, дээд сургууль, коллеж | *Public universities & colleges* | 19 896 | 231 | 16 449 | 3 102 | 114 |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 12 111 | 128 | 9 953 | 1 960 | 70 |
| Төрийн бус өмчийн их, дээд сургууль, коллеж | *Private universities & colleges* | 15 993 | - | 14 214 | 1 757 | 22 |
| Үүнээс: Эмэгтэй | *Of which: Female* | 9 737 | - | 8 576 | 1 144 | 17 |

Эх үүсвэр: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны мэдээгээр
*Source: Report of the Ministry of Education, Culture, Science and Sports*

## IV. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ
## *SOCIAL INSURANCE AND WELFARE*

4.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*REVENUE AND EXPENDITURE OF SOCIAL INSURANCE FUND, by types, as a first 9 months of selected years*

| Үзүүлэлтүүд | Indicators | 2015 | 2016 | | | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|---|---|
| | | I-IX | VIII | IX | I-IX | |
| **Нийгмийн даатгалын сангийн орлого, сая төг** | ***Revenue of social insurance fund, mln.tog*** | **1 044 472.5** | **156 541.3** | **184 072.9** | **1 303 408.7** | **124.8** |
| Үүнээс: | *Of which:* | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сан | *Pension insurance fund* | 710 558.3 | 118 772.8 | 121 530.3 | 926 831.3 | 130.4 |
| Тэтгэмжийн даатгалын сан | *Benefit insurance fund* | 61 268.3 | 7 901.0 | 9 117.0 | 63 496.9 | 103.6 |
| Эрүүл мэндийн даатгалын сан | *Health insurance fund* | 179 349.7 | 16 563.3 | 39 187.3 | 209 015.5 | 116.5 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сан | *IAOD* insurance fund* | 71 692.3 | 11 254.2 | 11 771.1 | 79 956.9 | 111.5 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | *Unemployment insurance fund* | 21 603.9 | 2 050.0 | 2 467.2 | 24 108.1 | 111.6 |
| **Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая төг** | ***Expenditure of social insurance fund, mln.tog*** | **1 153 480.8** | **146 585.1** | **164 081.9** | **1 276 651.3** | **110.7** |
| Үүнээс: | *Of which:* | | | | | |
| Тэтгэврийн даатгалын сан | *Pension insurance fund* | 898 601.9 | 113 246.7 | 118 878.0 | 983 262.1 | 109.4 |
| Тэтгэмжийн даатгалын сан | *Benefit insurance fund* | 66 960.7 | 8 139.7 | 10 647.1 | 70 245.7 | 104.9 |
| Эрүүл мэндийн даатгалын сан | *Health insurance fund* | 147 733.1 | 19 919.7 | 28 213.0 | 177 482.3 | 120.1 |
| ҮОМШӨ*-ний даатгалын сан | *IAOD* insurance fund* | 23 599.0 | 2 730.7 | 3 477.6 | 23 565.0 | 99.9 |
| Ажилгүйдлийн даатгалын сан | *Unemployment insurance fund* | 16 586.1 | 2 548.3 | 2 866.2 | 22 096.2 | 133.2 |

* ҮОМШӨ - Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
** IAOD - Industrial accident and occupational disease*

4.2 НИЙГМИЙН ДААТГАЛД АЛБАН ЖУРМААР ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, тэтгэврийн төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*NUMBER OF INSURED PERSONS FOR COMPULSORY SOCIAL INSURANCE AND PENSION ALLOCATED, by types of pensions, as a first 9 months of selected years*

| Үзүүлэлтүүд | Indicators | 2015 I-IX | 2016 I-IX | 2016 I-IX / 2015 I-IX % |
|---|---|---|---|---|
| **1. Албан журмаар даатгуулагчид** | ***1. Number of insured persons for compulsory insurance*** | **740 790** | **738 453** | **99.7** |
| Үүнээс: | *Of which:* | | | |
| Аж ахуйн нэгж, байгууллагынх | *Establishments & institutions* | 498 325 | 491 495 | 98.6 |
| Төсөвт байгууллагынх* | *Government budgetary organization** | 242 465 | 246 958 | 101.9 |
| **2. Олгосон тэтгэвэр, сая төг** | ***2. Amount of granted pensions, mln.tog*** | **870 530.7** | **963 196.8** | **110.6** |
| Үүнээс: | *Of which:* | | | |
| Өндөр настны | *Elderly pension* | 644 545.1 | 720 701.3 | 111.8 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн | *Disabled pensions* | 117 633.2 | 128 180.6 | 109.0 |
| Тэжээгчээ алдсаны | *Breadwinner loss pension* | 40 456.2 | 43 342.0 | 107.1 |
| Цэргийн | *Military pension* | 67 896.2 | 70 972.9 | 104.5 |

Эх үүсвэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын мэдээлэл
*Source: Report of the Government Implementing agency General Authority for Health and Social Insurance*

* - Төсөвт байгууллагаас нийгмийн даатгал төлж байгаа нийт хүний тоонд өөр ажилд шилжсэн, тэтгэвэр тогтоолгосон, ажлаас чөлөөлөгдсөн даатгуулагчдыг хамруулсан.
** - The number of total insurers, who pay social insurance contribution from the budget organizations has included insurers even they have shifted to another job, retired and released.*

4.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*PERSONS RECEIVED SOCIAL WELFARE SERVICES, AMOUNT OF GRANTED PENSIONS AND ALLOWANCES, by types, as a first 9 months of selected years*

| Үйлчилгээний төрөл | *Types of services* | Хүний too *Number of persons* | | |
|---|---|---|---|---|
| | | 2015 I-IX | 2016 I-IX | 2016 I-IX / 2015 I-IX % |
| **1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж** | ***1. Social welfare pensions and allowances*** | **192 636** | **250 565** | **130.1** |
| **Халамжийн тэтгэвэр** | ***Long-term pensions*** | **63 081** | **62 924** | **99.8** |
| **Нөхцөлт мөнгөн тэтгэмж** | ***Conditioned cash benefits*** | **129 555** | **187 641** | **144.8** |
| Үүнээс: | *Of which:* | | | |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн | *Allowances to pregnant or lactating mothers* | 89 272 | 126 485 | 141.7 |
| Ахмад настныг асарч буй иргэний | *Allowances for people caring elders* | 18 740 | 30 016 | 160.2 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний | *Allowances for persons taking care of disabled ones* | 19 096 | 28 257 | 148.0 |
| Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний | *Allowances for persons who adopted and brought of double orphans* | 2 447 | 2 883 | 117.8 |
| **2. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт** | ***2. Social welfare services and mitigations*** | **337 505** | **557 229** | **165.1** |
| Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Concessions for the elders* | 87 805 | 266 461 | 303.5 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Concessions for disabled people* | 13 318 | 16 745 | 125.7 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ | *Social welfare services* | 3 723 | 1 908 | 51.2 |
| Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж | *Social welfare incentives, conditioned cash benefits* | 229 804 | 269 457 | 117.3 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Benefits for honored elders* | 2 855 | 2 658 | 93.1 |
| **3. Хүний хөгжил сангийн хүүхдийн мөнгө** | ***3. Cash benefits for children aged below 18*** | **1 019 987** | **1 021 078** | **100.1** |

| | | Олгосон тэтгэвэр, тэтгэмж, сая төг *Total granted pensions, mln.tog* | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2015 | 2016 | | | 2016 I-IX / 2015 I-IX % |
| | | I-IX | VIII | IX | I-IX | |
| **1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж** | ***1. Social welfare pensions and allowances*** | **109 181.2** | **11 261.8** | **16 269.4** | **112 492.2** | **103.0** |
| **Халамжийн тэтгэвэр** | ***Long-term pensions*** | **62 245.2** | **6 278.5** | **9 002.1** | **62 995.4** | **101.2** |
| **Нөхцөлт мөнгөн тэтгэмж** | ***Conditioned cash benefits*** | **46 936.0** | **4 983.3** | **7 267.3** | **49 496.8** | **105.5** |
| Үүнээс: | *Of which:* | | | | | |
| Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн | *Allowances to pregnant or lactating mothers* | 27 030.2 | 2 666.2 | 3 788.0 | 26 415.1 | 97.7 |
| Ахмад настныг асарч буй иргэний | *Allowances for people caring elders* | 9 301.2 | 1 086.3 | 1 654.5 | 11 040.5 | 118.7 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэний | *Allowances for persons taking care of disabled ones* | 9 326.5 | 1 082.0 | 1 605.4 | 10 649.2 | 114.2 |
| Бүтэн өнчин хүүхэд үрчлэн өсгөсний | *Allowances for persons who adopted and brought of double orphans* | 1 278.1 | 148.8 | 219.4 | 1 392.0 | 108.9 |
| **2. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт** | ***2. Social welfare services and mitigations*** | **64 968.7** | **4 704.7** | **4 353.9** | **66 077.1** | **101.7** |
| Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Concessions for the elders* | 13 085.8 | 1 868.7 | 1 583.2 | 13 895.6 | 106.2 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Concessions for disabled people* | 3 902.6 | 422.4 | 659.2 | 4 090.0 | 104.8 |
| Нийгмийн халамжийн үйлчилгээ | *Social welfare services* | 916.2 | - | 111.7 | 1 142.0 | 124.6 |
| Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламж | *Social welfare incentives, conditioned cash benefits* | 43 617.1 | 2 031.8 | 1 351.2 | 43 777.4 | 100.4 |
| Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж | *Benefits for honored elders* | 3 447.0 | 381.8 | 648.6 | 3 172.1 | 92.0 |
| **3. Хүний хөгжил сангийн хүүхдийн мөнгө** | ***3. Cash benefits for children aged below 18*** | **184 067.2** | **-** | **36 828.2** | **159 374.6** | **86.6** |

Эх үүсвэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын мэдээлэл
*Source: Report of the Government Implementing agency General Office of Labour and Welfare Service*

## V. ЭРҮҮЛ МЭНД
## *HEALTH*

5.1 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*BIRTHS, DEATHS, MATERNAL AND CHILD MORTALITY, as a first 9 months of selected years*

| Хугацаа *Periods* | | Амаржсан эх *Mothers delivered child* | Амьд төрсөн хүүхэд *Live births* | Эхийн эндэгдэл *Maternal mortality* | Нас баралт *Deaths* | Нялхсын эндэгдэл *Infant mortality* | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл *Under-five mortality* |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2015 | I | 6 668 | 6 721 | 1 | 1 340 | 118 | 141 |
| | II | 6 043 | 6 077 | 1 | 1 292 | 94 | 105 |
| | III | 6 930 | 6 976 | 2 | 1 445 | 109 | 125 |
| | IV | 6 757 | 6 787 | 1 | 1 302 | 89 | 105 |
| | V | 6 883 | 6 932 | 3 | 1 360 | 127 | 142 |
| | VI | 6 741 | 6 759 | - | 1 418 | 93 | 120 |
| | VII | 7 061 | 7 106 | 1 | 1 318 | 97 | 127 |
| | VIII | 6 789 | 6 839 | 3 | 1 315 | 92 | 110 |
| | IX | 6 642 | 6 652 | 1 | 1 457 | 102 | 123 |
| | I-IX | 60 514 | 60 849 | 13 | 12 247 | 921 | 1 098 |
| 2016 | I | 6 275 | 6 304 | 3 | 1 317 | 121 | 140 |
| | II | 6 116 | 6 155 | 3 | 1 372 | 123 | 147 |
| | III | 6 652 | 6 682 | 6 | 1 457 | 183 | 204 |
| | IV | 6 241 | 6 259 | 5 | 1 411 | 149 | 174 |
| | V | 6 780 | 6 816 | 3 | 1 441 | 122 | 149 |
| | VI | 6 625 | 6 651 | 4 | 1 297 | 112 | 139 |
| | VII | 6 917 | 6 949 | 2 | 1 341 | 89 | 121 |
| | VIII | 6 903 | 6 944 | 3 | 1 355 | 78 | 109 |
| | IX | 6 533 | 6 560 | 2 | 1 301 | 86 | 114 |
| | I-IX | 59 042 | 59 320 | 31 | 12 292 | 1 063 | 1 297 |
| 2016 I-IX / 2015 I-IX | % | 97.6 | 97.5 | 238.5 | 100.4 | 115.4 | 118.1 |

5.2 АМАРЖСАН ЭХ, АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*MOTHERS DELIVERED CHILD AND LIVE BIRTHS, by regions, aimags and the capital, as a first 9 months of selected years*

| Аймаг, нийслэл *Aimags and the capital* | Амаржсан эх *Mothers delivered child* | | | | Амьд төрсөн хүүхэд *Live births* | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 I-IX | 2016 | | | 2015 I-IX | 2016 | | |
| | | VIII | IX | I-IX | | VIII | IX | I-IX |
| **Бүгд/*Total*** | **60 514** | **6 903** | **6 533** | **59 042** | **60 849** | **6 944** | **6 560** | **59 320** |
| **Баруун бүс /*Western region*** | **7 560** | **922** | **782** | **7 405** | **7 583** | **920** | **791** | **7 422** |
| БӨ/*BO* | 2 129 | 266 | 227 | 2 124 | 2 136 | 261 | 227 | 2 117 |
| ГО/*GO* | 966 | 121 | 79 | 914 | 973 | 120 | 79 | 915 |
| ЗА/*ZA* | 1 222 | 138 | 116 | 1 120 | 1 223 | 139 | 117 | 1 124 |
| УВ/*UV* | 1 518 | 188 | 180 | 1 552 | 1 529 | 187 | 184 | 1 562 |
| ХО/*KHO* | 1 725 | 209 | 180 | 1 695 | 1 722 | 213 | 184 | 1 704 |
| **Хангайн бүс/*Khangai region*** | **10 383** | **1 174** | **1 109** | **9 879** | **10 429** | **1 180** | **1 117** | **9 912** |
| АР/*AR* | 1 564 | 160 | 169 | 1 480 | 1 573 | 161 | 171 | 1 483 |
| БХ/*BKH* | 1 588 | 198 | 164 | 1 503 | 1 593 | 200 | 164 | 1 507 |
| БУ/*BU* | 777 | 62 | 72 | 670 | 784 | 61 | 72 | 670 |
| ОР/*OR* | 2 016 | 241 | 228 | 1 941 | 2 028 | 243 | 233 | 1 958 |
| ӨВ/*OV* | 2 060 | 233 | 237 | 2 036 | 2 066 | 234 | 238 | 2 041 |
| ХӨ/*KHS* | 2 378 | 280 | 239 | 2 249 | 2 385 | 281 | 239 | 2 253 |
| **Төвийн бүс/*Central region*** | **7 749** | **829** | **828** | **7 462** | **7 784** | **836** | **825** | **7 488** |
| ГС/*GS* | 335 | 36 | 35 | 351 | 337 | 37 | 36 | 354 |
| ДА/*DA* | 1 998 | 218 | 217 | 1 878 | 2 012 | 219 | 219 | 1 889 |
| ДО/*DO* | 1 180 | 118 | 110 | 1 077 | 1 194 | 117 | 110 | 1 083 |
| ДУ/*DU* | 730 | 70 | 82 | 742 | 733 | 71 | 80 | 738 |
| ӨМ/*OM* | 1 095 | 104 | 113 | 1 050 | 1 092 | 108 | 113 | 1 056 |
| СЭ/*SE* | 1 447 | 177 | 186 | 1 432 | 1 455 | 179 | 185 | 1 440 |
| ТӨ/*TO* | 964 | 106 | 85 | 932 | 961 | 105 | 82 | 928 |
| **Зүүн бүс/*Eastern region*** | **3 802** | **448** | **405** | **3 802** | **3 816** | **452** | **406** | **3 820** |
| ДД/*DD* | 1 474 | 198 | 170 | 1 578 | 1 484 | 201 | 172 | 1 586 |
| СҮ/*SU* | 1 046 | 112 | 101 | 964 | 1 046 | 114 | 100 | 973 |
| ХЭ/*KHE* | 1 282 | 138 | 134 | 1 260 | 1 286 | 137 | 134 | 1 261 |
| **Улаанбаатар/*Ulaanbaatar*** | **31 020** | **3 530** | **3 409** | **30 494** | **31 237** | **3 556** | **3 421** | **30 678** |
| УБ/*UB* | 31 020 | 3 530 | 3 409 | 30 494 | 31 237 | 3 556 | 3 421 | 30 678 |

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яамны сар бүрийн мэдээлэл
*Source: Monthly report of the Ministry of Health*

5.3 НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ, бүс, аймаг, нийслэлээр, жил бүрийн эхний 9 сарын байдлаар
*INFANT MORTALITY, by regions, aimags and the capital, as a first 9 months of selected years*

| Аймаг, нийслэл<br>*Aimags and the capital* | Нялхсын эндэгдэл<br>*Infant mortality* | | | | 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл<br>*Infant mortality rate per 1000 live births* | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 I-IX | 2016 | | | 2015 I-IX | 2016 | | |
| | | VIII | IX | I-IX | | VIII | IX | I-IX |
| **Бүгд/*Total*** | **921** | **78** | **86** | **1 063** | **15.1** | **11.2** | **13.1** | **17.9** |
| **Баруун бүс/*Western region*** | **154** | **13** | **10** | **174** | **20.3** | **14.1** | **12.6** | **23.4** |
| БӨ/*BO* | 46 | 4 | 3 | 69 | 21.5 | 15.3 | 13.2 | 32.6 |
| ГО/*GO* | 14 | 1 | 4 | 17 | 14.4 | 8.3 | 50.6 | 18.6 |
| ЗА/*ZA* | 36 | 2 | - | 18 | 29.4 | 14.4 | - | 16.0 |
| УВ/*UV* | 28 | 2 | 2 | 40 | 18.3 | 10.7 | 10.9 | 25.6 |
| ХО/*KHO* | 30 | 4 | 1 | 30 | 17.4 | 18.8 | 5.4 | 17.6 |
| **Хангайн бүс/*Khangai region*** | **167** | **11** | **14** | **212** | **16.0** | **9.3** | **12.5** | **21.4** |
| АР/*AR* | 25 | 1 | - | 27 | 15.9 | 6.2 | - | 18.2 |
| БХ/*BKH* | 26 | 1 | 4 | 41 | 16.3 | 5.0 | 24.4 | 27.2 |
